



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал,
үр дүн

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын
үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төсвийн
хуваарилалтыг оновчтой шийдвэрлэх бодлого дутагдаж
байна.

Аудитын код: ГАГ-2019/11/-ГА

Цахим хуудас:
www.audit.mn
Дорноговь аймаг
2019 оны 11 сар

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 70522734 Цахим хаяг:
dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхцэцэг
Утас: 70523020 Цахим хаяг:
enkhtsetseg.e@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Лүндэгмаа
Цахим хаяг:
lundegmaa.ts@audit.gov.mn

Аудитор: П.Энхбаяр
Цахим хаяг:
enkhbayar.p@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	2
Хүснэгтийн товьёг.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4-5
БҮЛЭГ 1. ТӨРӨӨС СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО ОНОВЧТОЙ БАЙНА.....	6-15
А.1. СӨБ олгох хууль эрх зүйн орчин хангалттай ч холбогдох дүрэм, журам батлагдаж гараагүйгээс хэрэгжүүлэхэд хүндрэл үүсч байна.....	6-11
<i>А.1.1 Засгийн газар болон холбогдох яамдын сайд хуулиар заасан дүрэм журмыг бүрэн боловсруулаагүй байна.</i>	<i>6-10</i>
<i>А.1.2. 2 Бодлого хэрэгжүүлэх механизм, арга хэмжээг харилцан уялдаатай тусгаж боловсруулсан байна.</i>	<i>10-11</i>
А.2 СӨБ-ын бодлогыг хэрэгжүүлэх чиг үүргийн хуваарилалт оновчтой байна.	11-12
<i>А.2.1 Орон нутагт СӨБ-ын бодлого хэрэгжүүлэх удирдлагын чиг үүргийн хуваарилалт оновчтой байна.....</i>	<i>11-14</i>
<i>А.2. 2.2 СӨБ-ын санхүүгийн тогтолцоо, чиг үүргийн хуваарилалт оновчтой байна.....</i>	<i>14-15</i>
БҮЛЭГ 2. СӨБ олгох бодлогод өөрчлөлт оруулж хэрэгжилтийг үр нөлөөтэй, үр дүнтэй зохион байгуулах хэрэгтэй байна.	16-43
Б.1 СӨБ олгох үйлчилгээний төлөвлөлт хангалтгүй, хүртээмж дутмаг байна.	16-25
<i>Б.1.1. СӨБ-ын байгууллагын бодит хэрэгцээ шаардлага их байгаа ч санхүүгийн хязгаарлагдмал нөөцийн хэмжээнд хүн амын нягтаршил, барилгын чанар байдалтай уялдуулан төлөвлөсөн байна.</i>	<i>16-19</i>
<i>Б.1.2 Орон нутгийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд СӨБ-ын байгууллагын хэрэгцээг тусгасан байна.....</i>	<i>19-20</i>
<i>Б.1.3 Цэцэрлэгт хамрагдвал зохих бүх насны хүүхэд СӨБ олгох үйлчилгээнд бүрэн хамрагдаж чадахгүй байна.....</i>	<i>20-25</i>
Б.2 СӨБ олгох үйл ажиллагаа нь мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдаагүй байна.	25-30
<i>Б.2.1. СӨБ-ын байгууллагад хүний нөөцийн хүрэлцээ дутмаг байна.</i>	<i>25-27</i>
<i>Б.2.2 Хүний нөөц мэргэжлийн зохих шаардлагыг хангаагүй байна.</i>	<i>27-30</i>
Б.3 СӨБ-ын үйл ажиллагаанд олгож байгаа төсвийг зардал болон цэцэрлэгүүдийн хооронд гүйлгэн зарцуулж анхны батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.	30-37
<i>Б.3.1. Төсвийг зардлын нормативаар хуваарилж буй нь бодитой бус байгаагаас төлөвлөлт, хуваарилалт оновчгүй байна.....</i>	<i>30-34</i>
<i>Б.3.2 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.....</i>	<i>34-37</i>
Б.4. Хууль журмын заалтыг мөрдөж ажиллаагүйгээс СӨБ олгох үйлчилгээнд тавьж буй хяналт хангалтгүй байна.....	37-43
<i>Б.4.1. СӨБ олгох байгууллагын түвшинд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.</i>	<i>37-40</i>
<i>Б.4.2 Боловсролын газар, мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт шалгалтын дагуу шаардлагатай арга хэмжээг бүрэн авч хэрэгжүүлээгүйгээс шалгалтын үр нөлөө хангалтгүй байна.....</i>	<i>40-43</i>
Холбогдох байгууллагын санал:	44
ДҮГНЭЛТ:	45
5	
ЗӨВЛӨМЖ:	46

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БСШУС	Боловсрол соёл шинжлэх ухааны сайд
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
БСУГ	Боловсрол соёл урлагын газар
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СӨБТХ	Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
БТХ	Боловсролын тухай хууль
МУ	Монгол улс
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТАХ	Төсөл арга хэмжээ
ХБТХ	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НХХС	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд
СС	Сангийн сайд
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УБТЗ	Улаанбаатар төмөр зам
ҮАГ	Үндэсний аудитын газар
БГАҮ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ
НУТУ	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Сургалтын чиглэл, ерөнхий болон тусгай чадвар, агуулгын бүрэлдэхүүн хэсгийн тоо хэмжээ	
Хүснэгт 2	Цэцэрлэгт хамрагдсан хүүхэд, ажилласан багшийн тоо	
Хүснэгт 3	Хүн ам, цэцэрлэгийн насны хүүхдийн тоо болон хүчин чадлын хамаарал, төлөвлөсөн барилга, хэрэгжилтийн судалгаа	
Хүснэгт 4	Газар болон барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон шийдвэрийн судалгаа	
Хүснэгт 5	Цэцэрлэгт хамрагдах болон хамрагдсан хүүхдийн статистик судалгаа	
Хүснэгт 6	Хувийн өмчийн цэцэрлэгийн хүчин чадал, хамрагдалтын судалгаа.	
Хүснэгт 7	Хүчин чадлаас давсан хүүхэд, нэг багшид ногдох хүүхдийн тооны судалгаа	
Хүснэгт 8	Өдрийн дэглэмийн хуваарь	
Хүснэгт 9	Ажиллагсдын тооны судалгаа	
Хүснэгт 10	Цэцэрлэгийн эрхлэгчдийн ажлын туршлагын судалгаа	
Хүснэгт 11	Сургалтанд хамрагдсан багш нарын судалгаа	
Хүснэгт 12	Төсвийн төслийн судалгаа	
Хүснэгт 13	Төсөвт орсон өөрчлөлтийн судалгаа	
Хүснэгт 14	Бусад хувьсах зардлын нормативт төсөв, батлагдсан төсвийн харьцуулалтын судалгаа	
Хүснэгт 15	Хувилбарт сургалтын зардлын төсөв	
Хүснэгт 16	Хоолны зардлын судлгаа	

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1		

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Тэтгэвэр тогтоолгоход авсан тэтгэмжийн судалгаа	

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	СӨБ-ын байгууллагуудын 2016-2018 оны төсөвт орсон өөрчлөлтийн судалгаа	

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2019 оны 04 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын "Аудитын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" 2019 оны А/45 дугаар тушаалын дагуу "Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн"-д Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.
Аудитын зорилт	Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүнд улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: ➤ Төрөөс сургуулийн өмнөх боловсролын талаар баримталж буй бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоо оновчтой байгаа эсэх; ➤ Бодлогын хэрэгжилт үр нөлөөтэй, үр дүнтэй байгаа эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг аймгийн ЗДТГ, БСУГ, ГХБХБГ, МХГ, Сайншанд сумын I цэцэрлэг, II цэцэрлэг, IX цэцэрлэг, XI цэцэрлэг, XII цэцэрлэг, Замын-Үүд сумын III цэцэрлэг, Y цэцэрлэг, Ухаалаг багачууд хувийн өмчийн цэцэрлэгүүдийн 2016-2018 оны үйл ажиллагааг /сүүлийн 3 хичээлийн жил/ хамруулан гүйцэтгэлээ.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторовын баталсан дэд төлөвлөгөө хөтөлбөр, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материал, сүүлийн 3 жилийн байдлаарх үндсэн үзүүлэлтийн судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Ч.Ариунаа удирдаж, аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Энхцэцэг чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Лүндэгмаа, аудитор П.Энхбаяр нар хамтран гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөөг 2019 оны 09 дугаар сарын 17-ний өдөр батлуулж, талбарын ажлыг 2019 оны 09 дугаар сарын 17-ны өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 28-ний өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 11 дугаар сарын 01-ний өдрийн дотор бичиж холбогдох үе шатны хяналтаар хянуулан Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулж, 2019 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн дотор ҮАГ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

Хүндрэл бэрхшээл

.....

А.1. СӨБ олгох хууль эрх зүйн орчин хангалттай ч холбогдох дүрэм, журам батлагдаж гараагүйгээс хэрэгжүүлэхэд хүндрэл үүсч байна.

А.1.1 Засгийн газар болон холбогдох яамдын сайд хуулиар заасан дүрэм журмыг бүрэн боловсруулаагүй байна.

1.1.1. СӨБ-ын талаар гарсан бодлого, хөтөлбөрүүд харилцан уялдаатай батлагдсан байна.

Улсын Их Хурлаар 1995 онд баталсан Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын хүрээнд дараах бодлогын баримт бичиг батлагдаж хэрэгжсэн байна.

- Монгол Улсын Засгийн газраас боловсролын салбарт 1997-2005 онд хийх өөрчлөлтийн үндсэн чиглэл,
- Бүх нийтэд суурь боловсрол эзэмшүүлэх үндэсний хөтөлбөр,
- Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөрийн 1, 2, 3 дугаар үе шат,
- Сургуулийн өмнөх боловсролын 1, 2 дугаар шат,
- Албан бус боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр

Түүнчлэн Боловсролын багц хууль шинээр батлагдаж, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлтүүд орж хэрэгжиж эхэлсэн байна.

УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын баримт бичигт: "Боловсролын бүх шатны стандарт, сургалтын хөтөлбөрийг тухайн үеийн суралцагчийн хэрэгцээ, нийгмийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох зорилтууд дэвшүүлж, "Боловсрол" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ" гэж заажээ. МУ-ын Засгийн газрын 2010 оны 31 дүгээр тогтоолоор дээрх хөтөлбөрүүдийг дэд хөтөлбөр шинжтэйгээр багтаасан 2010-2021 онд хөгжүүлэх "Боловсрол" үндэсний хөтөлбөр батлагдсан байна.

Дээрх хөтөлбөрийн хүрээнд БСШУС-ын 2013 оны А/327 тоот тушаалаар Сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлогыг баталж дараах зорилтыг дэвшүүлсэн байна.

- Бага насны хүүхдийн суралцахуйн талаар дэлхийн улс орнуудын баримталж байгаа чиг хандлага, монгол хүүхдийн онцлогт баримжаалан сургуулийн өмнөх насны хүүхдийн сургалтын хөтөлбөрийг хөгжүүлнэ,
- Сургалтын хөтөлбөрийн зорилго, агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээ нь хүүхдийн хөгжлийн ахиц, амжилтын үр дүнд чиглэсэн нээлтэй байх
- СӨБ олгох байгууллага сургалтын хөтөлбөрөө байгууллагынхаа үзэл баримтлалыг үндэслэн боловсруулах.

УИХ-ын 2015 оны 12 дугаар тогтоолоор Төрөөс боловсролын талаар 2014-2024 онд баримтлах бодлогыг шинэчлэн баталж, Боловсролын тухай хуульд¹ сургалтын цөм

¹ Боловсролын тухай хуулийн 3.1.18-д "сургалтын цөм хөтөлбөр" гэж тухайн шатанд суралцагчийн эзэмших мэдлэг, ур чадвар, төлөвшлийн түвшин, түүнд хүрэх цогц үйл ажиллагааны ерөнхий зохион байгуулалтыг илэрхийлсэн баримт бичгийг; 11.4-д Сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг өмчийн бүх хэлбэрийн боловсролын сургалтын байгууллага дагаж мөрдөнө

хөтөлбөртэй холбоотой заалтыг тусган нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, Сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлоготой уялдуулан БСШУС-ын 2015 оны А/301 тоот тушаалаар СӨБ-ын Сургалтын цөм хөтөлбөрийг баталжээ.

1.1.2. Төрийн захиргааны төв байгууллагууд холбогдох дүрэм журам, норм нормативыг бүрэн боловсруулж батлаагүй байна.

Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд сургуулийн өмнөх боловсрол олгох үйлчилгээтэй холбоотой заалтыг хэрэгжүүлэх, мөрдөхөд чиглэгдсэн норматив, дүрэм, журам боловсруулж батлахыг төрийн захирагааны төв байгууллагуудад заасан боловч холбогдох дүрэм, журам боловсруулж батлагдаагүй байна. Тухайлбал:

- Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 8.15-д Сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа байгууллагын нэг багшид ногдох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог боловсролын нийгмийн хамгааллын, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно гэж заасан. СӨБ-ын байгууллагын нэг багшид ногдох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог тогтоосон тушаал шийдвэр гараагүйгээс Сайншанд сумын 11-р цэцэрлэгийн ХБХ-ийн ангид 2 багш, 14 хүүхэдтэй ажиллаж байна.
- Хуулийн 7.1-д Хүүхдийн чадвар, чадамж, хөгжлийн ахицыг үнэлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж заасан. Хүүхдийн чадвар, чадамж, хөгжлийн ахицыг үнэлэх журам батлагдаж гараагүйгээс сургалтын цөм хөтөлбөрт тусгагдсан ахицын үнэлгээний хуудсаар үнэлж байна.
- Хуулийн 7.2-д Цэцэрлэгийн үйлчилгээний чанарыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу үнэлж, дүгнэнэ гэж заасны дагуу батлагдсан журам байхгүй.
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Боловсролын тухай хуулийн 8.6-д заасан Тусгай, гэр цэцэрлэг болон сувиллын цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм, асрамжийн болон халамжийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийг боловсруулаагүйгээс орон нутагт ХБХ сурах нөхцөл боломжоор хангагдахгүй байна
- Хуулийн 40.3-д Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн, аймгийн төвөөс бусад сум, тосгон, багийн сургуульд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно гэж заасан. Гэвч хувьсах зардлын өсөн нэмэгдэх итгэлцүүрийг жил бүр тогтоож өгөөгүйгээс Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор тогтоосон 1650 төгрөгөөр цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг тооцон олгож байна.

Хуулийн дагуу дүрэм, журам бүрэн боловсруулж батлаагүйгээс сургуулийн өмнөх боловсрол олгох эрх зүйн орчин хангалтгүй байна.

1.1.3. Сургалтын цөм хөтөлбөр хүүхэд өдөр тутамд шаардлагатай бие бялдар, эрүүл мэндийн дадал чадварыг хөгжүүлэх агуулгатай байна.

СӨБТ-хуулийн 3.1-д СӨБ-ын зорилго нь Бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино гэж заасан.

Сургалтын цөм хөтөлбөр нь хүүхэд бүрийг бие, сэтгэлээр эрүүл өсгөн бойжуулахад багш, судлаач, эцэг эх хамтран ажиллахад дэмжлэг үзүүлж, хүүхэд бүр өөрийн онцлог, бүтээлч үйлээрээ хөгжих боломж олгох зорилготой бөгөөд дараах зорилтыг дэвшүүлсэн байна.

- Биеийн болон хурууны хөдөлгөөнөө зохицуулах, эрүүл амьдрах дадал хэвшил эзэмших
- Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйл, бусадтай харилцах харилцаагаа удирдаж зохицуулах
- Санаа бодол, мэдлэг төсөөллөө хэл яриа болон зурж дүрслэх, урлан бүтээх үйлээрээ илэрхийлэх
- Тойрон хүрээлж буй байгаль, нийгмийн орчныг сонирхох, судлах, зохистой харилцах
- Тоо хэмжээ хэлбэр дүрс орон зай, цаг хугацааны талаар ойлголт төсөөлөлтэй болох
- Хөгжим, дүрслэх урлагийг сонирхон таашаах, дуулах, хөгжмийн хэмнэлийг мэдэрч хөдөлгөөн хийх

Сургалтын цөм хөтөлбөрийн агуулга нь хүүхдийн эзэмших чадвараар тодорхойлогдох бөгөөд сургуулийн өмнөх насанд хүүхэд сургалтын 6 чиглэлээр 7 ерөнхий чадвар, 41 тусгай чадвар эзэмшихээр заажээ. *Сургалтын чиглэл, ерөнхий болон тусгай чадвар, агуулгын бүрэлдэхүүн хэсгийн тоо хэмжээг хүснэгт №1-ээр харуулав.*

Хүснэгт №1

№	Сургалтын чиглэл	Ерөнхий чадвар	Тусгай чадвар	Агуулгын бүрэлдэхүүн
1	Хөдөлгөөн эрүүл мэнд	7	9	4
2	Зан чанар харилцаа		9	7
3	Хэл яриа		6	5
4	Байгаль нийгмийн орчин		4	5
5	Математикийн энгийн төсөөлөл		5	6
6	Дуу хөгжим, дүрслэх урлаг		8	9
	Дүн	7	41	36

Цөм хөтөлбөрт хүүхдийн эзэмших чадварыг I-III хүртэл ахисан түвшингээр томьёолсон байна. Суралцахуйн чиглэлүүд нь хүүхдийн бие бялдар, оюун ухаан, сэтгэл хөдлөл, нийгэмшихүйн хөгжлийг бүхэлд нь хамруулсан, хүүхэд өдөр тутамд шаардлагатай бие бялдар, эрүүл мэндийн дадал чадварыг хөгжүүлэх олон талын агуулгатай байна.

Сургалтын цөм хөтөлбөрт сургалтын чиглэл бүрээр заасан тусгай чадварыг хүүхэд эзэмшсэнээр сургалтын цөм хөтөлбөрийн зорилго, зорилт хэрэгжих, тэдэнд ерөнхий чадварууд суух нөхцөл бүрдэнэ, мөн хүүхэд бүрийн чадвар, чадамжийн ахицын үнэлгээ нь цогц, тэдний нийтлэг онцлог дүр төрхийг тодруулсан, бодитой байх, өдөр тутмын хөгжүүлэх үйл ажиллагааны явцад ажиглалтын аргаар хийгдэнэ гэж заасан.

Цэцэрлэгийн багш ажилтнуудаас авах санал асуулгад 8 цэцэрлэгийн 34 багш ажилтан хамрагдсан бөгөөд *Салбарын яамнаас баталсан сургалтын хөтөлбөр*

өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэж байна уу гэсэн асуултанд 52 хувь нь дараах шалтгааны улмаас нийцэхгүй байна гэсэн хариулт ирүүлсэн. Тухайлбал:

- Хүүхдэд өдөр тутамд шаардлагатай бие бялдар, эрүүл мэндийн дадал чадварыг хөгжүүлэх агуулга нь хүндэдсэн
- Өдөр тутамд хүүхдэд таарсан, хэвшүүлэх боломжтой, дадал болохоор зүйлийг оруулж өгөх.
- Хөтөлбөрийг орчин цаг үетэйгээ нийцүүлж сайжруулах.
- Хүүхдийн ахицын үнэлгээний асуулт дэлгэрэнгүй олон бөгөөд ажлын ачааллаас шалтгаалж үнэн зөв үнэлэх боломжгүй.
- Хэл яриа, өөрийгөө илэрхийлэх чадвар, хөдөлгөөн эрүүл мэндийн чадварын агуулга дээр хүүхдийн нас бие бялдарын онцлогт тохирсон агуулга байхгүй
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгайлсан чадвар, чадамж байхгүй

Цөм хөтөлбөрийн давуу тал нь тухайн цэцэрлэг, багш өөрийн нөөц, давуу тал дээрээ тулгуурлан хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх онцлогтой ч цэцэрлэгийн өөрийн боловсруулсан дүрэм, сургалтын хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө болон багш нарын мэдлэг, ур чадвараас шалтгаалан хүүхэд бүрийг сургах, хөгжүүлэх үйл ажиллагаа харилцан адилгүй байна.

Аудитад хамрагдсан цэцэрлэгүүдээс Сайншанд сумын 12-р цэцэрлэгийн сургалтын орчин хөдөлгөөн эрүүл мэндийн танхимыг байгуулж, загас, шувуу, мэлхий зэрэг амьтан, ургамал цэцгээр тохижуулсан нь хүүхдийг хөгжүүлэх орчинг өдөр тутам сольж сонирхолтой болгох, бодит орчноос хүүхэд өөрөө мэдлэгээ бүтээх үйлийн эзэн байх нөхцлийг бүрдүүлсэн нь давуу байна.

1.1.4. Цэцэрлэгүүд өөрийн үйл ажиллагааны онцлогийг тусгасан дүрэм, сургалтын хөтөлбөртэй байна.

БСШУС-ын 2005 оны 405 дугаар тушаалаар Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм, БСШУСС-ын 2019 оны А/118 дугаар тушаалаар дүрмийг шинэчлэн баталсан. Тушаалд үлгэрчилсэн дүрмийг баримтлан цэцэрлэгийн хэв шинж, өөрийн үйл ажиллагааны онцлогийг тусгасан дүрэм батлаж мөрдөхийг цэцэрлэгийн эрхлэгч нарт, хяналт тавьж ажиллахыг Боловсролын газарт тус тус даалгасан байна.

Аудитад хамрагдсан цэцэрлэгүүд цэцэрлэгийн дүрмээ боловсруулж, багш ажилчдын болон зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж баталсан байна. Харин Замын-Үүд сумын Ухаалаг багачууд хувийн цэцэрлэг өөрийн хэв шинж, үйл ажиллагааны онцлогийг тусгасан дүрэм боловсруулаагүй байхад БСУГ хяналт тавьж, чиглэл өгч ажиллаагүй.

Сургалтын цөм хөтөлбөрийг цэцэрлэг тус бүр өөрийн сургалтын хөтөлбөрөөр хэрэгжүүлсэн бөгөөд багш нар сургалтын хөтөлбөрөө хүүхэд бүрийг хэрхэн хөгжүүлж төлөвшүүлэх арга замаа тодорхойлсон үзэл баримтлалдаа тулгуурлан боловсруулсан байна. Цэцэрлэгийн эрхлэгч сургалтын хөтөлбөрийг суралцахуйн 7 чиглэл, түвшинг баталж, багш нар батлагдсан хөтөлбөрөөс агуулгын задаргаа боловсруулан сэдэвчилсэн жилийн болон 7-14 хоногийн төлөвлөгөө батлуулан ажилласан байна.

Сургалтын цөм хөтөлбөрт ХБХ-ийг хэрхэн хөгжүүлэх талаар тусгагдаагүйгээс сургалтын хөтөлбөрийг 0-3 хүртлэх насны чадварт нийцүүлэн агуулгыг боловсруулж, хөдөлгөөнийг дэмжих, сэргээн засах энгийн аргуудыг хэрэглэж ирсэн байна.

Сайншанд сумын 11 цэцэрлэгийн ХБХ-ийн бүлэгт сургуулийн насны 7 хүүхэд хамрагдаж байгаа нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 7^{1.2}-д Сургуулийн өмнөх боловсролд хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны бүх хүүхдийг хамруулна гэж заасныг зөрчиж байна.

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 9.9-д Хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгийн ердийн бүлгийн хүүхдүүдтэй хамт сургаж болох бөгөөд хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүртэл хүүхэд нэг бүлэгт байж болно гэж заасан. Гэтэл Сайншанд сумын 11-р цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 1 анги /бүлэг/ байгаа бөгөөд тус бүлэгт 2016-2017 оны хичээлийн жилд 2-7 насны 13 хүүхэд, 2017-2018 оны хичээлийн жилд 2-9 насны 14 хүүхэд, 2018-2019 оны хичээлийн жилд 2-11 насны 14 хүүхэд хамрагдсан байна.

А.1.2 Бодлого хэрэгжүүлэх механизм, арга хэмжээг харилцан уялдаатай тусгаж боловсруулсан байна.

1.2.1. Сургуулийн өмнөх боловсрол олгох үйлчилгээ хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байна.

МУ-ын УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдаж, СӨБ-ын талаар дараах зорилтыг дэвшүүлсэн байна.

- “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийг хэрэгжүүлж хот суурин газарт хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах боломжийг бий болгоно.
- Анги дүүргэлт хэт өндөртэй сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулж, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжид шилжүүлнэ.
- Цэцэрлэг, сургуулийн орчин гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио, камер, автомашины хурд сааруулагчтай болгоно.
- Боловсролын түвшин, чиглэл тус бүрээр үнэлгээний систем, шалгуур, аргачлалыг хянан сайжруулж үйлчилгээний чанар, үр дүнг эцэг, эх, суралцагчдын оролцоотой үнэлэх боломжтой болгоно.
- Хүүхдийг амьдрах ухаанд сургаж, харилцааны зөв хэвшилтэй, бусдыг хүндлэх, хариуцлагатай, итгэл даах чадвартай болгон төлөвшүүлэх цогц бодлого хэрэгжүүлнэ.
- Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд хүүхдийг хүнлэг, эх оронч, үндэсний ухамсар, бахархалтай иргэн болж төлөвшүүлэхэд чиглэсэн мэдлэг, хүмүүжил олгох агуулгыг тусган хэрэгжүүлнэ.

МУ-ын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан дээрх зорилтыг аймгийн ИТХ-ын 2016 оны 02/11 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаж, орон нутагт СӨБ олгох талаар дараах зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

- Бүх шатны боловсрол, сургалтын байгууллагад хүүхэд, залуучуудыг эрсдэлгүй, осол эндэлгүй, аюулгүй, эрүүл мэнд амьдрах чадвартай болгох аюулгүй байдлын сургалтыг зохион байгуулах
- Цэцэрлэг сургуулийн орчинг хашаажуулах, гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио, камер, автомашины хурд сааруулагчтай болно.
- Алтанширээ, Даланжаргалан, сумын Олон овоо баг, Мандах, Замын-Үүд, Сайншанд сумын 1.5.6-р багуудад цэцэрлэгийн барилга шинээр барих, Сайншанд сумын 5.8-р цэцэрлэг, Замын-Үүд сумын 1-р цэцэрлэгийн барилгыг өргөтгөн барьж, сумдын цэцэрлэгийн барилгад их засвар хийж, хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан СӨБ-ын үйлчилгээнд хамруулахыг дэмжинэ.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд үе тэнгийхэнтэйгээ хамт суралцах таатай орчныг бүрдүүлнэ

МУ-ын Засгийн газрын мөрийн хөтөлбөр болон аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн дээрх зорилтыг аймаг, сумын ИТХ-аар батлагдсан эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон холбогдох байгууллагууд үр дүнгийн гэрээ, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлсэн байна.

БСУГ-ын төсвийн шууд захирагч нь төсвийн ерөнхийлөн захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулж, тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан ажилладаг байна. Тухайлбал: Тус газрын 2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд СӨБ-ын талаар дараах ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

- Сургууль цэцэрлэг соёлын төвийн болон багш нарын үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгч, зөвлөн тусалж, мэргэжил арга зүйн дэмжлэг тусалцаа үзүүлнэ.
- Хүүхэд бүр цэцэрлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлж, 5 настай хүүхдийг бүрэн хамруулан, СӨБ хамран сургалтын хувийг нэмэгдүүлнэ.
- Сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, эцэг, эхчүүдийг цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаанд оролцуулж, мэдээллээр хангах зорилгоор Эцэг эхээ, хүүхдээ сонсоё-444 арга хэмжээг зохион байгуулах
- СӨБ болон ЕБС-ын хүүхдийн эх хэлээрээ алдаагүй зөв бичих, ярих, илтгэх, сэтгэх, хэрэглээний бүрэн ур чадвартай болгох хэрэгцээнд нийцүүлэн монгол хэлний сургалтыг сайжруулах хүрээнд олон талт ажил зохион байгуулна.
- Бүх шатны боловсрол, сургалтын байгууллагад хүүхэд, залуучуудыг эрсдэлгүй, осол эндэлгүй, аюулгүй, эрүүл мэнд амьдрах чадвартай болгох аюулгүй байдлын олон талт сургалтыг зохион байгуулах
- Цэцэрлэг сургуулийн орчинг хашаажуулах, гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио, камер, автомашины хурд сааруулагчтай болно.
- Зарим сургууль цэцэрлэг соёлын байгууллагын барилгад үе шаттай засварын ажил хийж, зарим сумдад шинэ сургууль цэцэрлэг барилгыг эхлүүлж, ашиглалтад хүлээн авна.

СӨБ-ын байгууллагын төсвийн шууд захирагч нь төсвийн ерөнхийлөн захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулж, хөгжлийн бодлогын дээрх баримт бичигтэй уялдуулан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж БСУГ-ын даргаар батлуулсан байна.

Орон нутагт авч хэрэгжүүлж буй СӨБ олгох үйлчилгээ нь хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байна.

А.2 СӨБ-ын бодлогыг хэрэгжүүлэх чиг үүргийн хуваарилалт оновчтой байна.

А.2.1 Орон нутагт СӨБ-ын бодлого хэрэгжүүлэх удирдлагын чиг үүргийн хуваарилалт оновчтой байна.

2.1.1. СӨБ-ын бодлого хэрэгжүүлэх орон нутгийн удирдлагын чиг үүргийн хуваарилалт оновчтой байна.

Аймгийн ИТХ боловсролын асуудлаар хуульд заасны дагуу Засаг даргын тайлан хэлэлцэж, чиглэл өгөхөөс гадна орон нутгийн өмчийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх дэд хөтөлбөр батлаж, биелэлтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

- Аймгийн Засаг дарга хуульд заасан дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. орон нутгийн өмчийн цэцэрлэг байгуулах асуудлыг боловсролын газрын дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэх;
- өөрийн орлогоо нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, тоног төхөөрөмж, ном, сурах бичгээр хангах ажлыг зохион байгуулах;
- цэцэрлэгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох;
- цэцэрлэгийг зориулалтын барилга байгууламжаар хангах;
- боловсролын газрын болон цэцэрлэгийн удирдлага томилох, чөлөөлөх

Боловсролын тухай хуулийн 27.1-д Боловсролын удирдлага нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, боловсролын байгууллагын болон түүний өөрийн удирдлагаас бүрдэнэ гэж заасан.

Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь аймгийн Боловсрол соёл урлагийн газар бөгөөд удирдлагыг аймгийн Засаг дарга сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилсон байна.

Боловсролын тухай хуулийн 27.3-д Аймаг, нийслэлийн боловсролын газрын дэргэд тухайн нутаг дэвсгэрт явуулах боловсролын үйл ажиллагааны бодлого, хөгжлийн төлөвлөлтийн асуудлаар зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллана гэж заасан. Тус газрын дэргэд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх орон тооны бус зөвлөл байгуулагдаагүй байна.

Боловсролын тухай хуульд 30.1.15-д аймаг, нийслэлийн боловсролын газрын сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг томилох, тэдгээрийг үр дүнгийн гэрээний хэрэгжилт болон аймаг, нийслэлийн боловсролын газрын саналыг үндэслэн чөлөөлөх гэж заасан.

БСУГ-ын даргын 2018 оны А/20, А/36 тоот тушаалаар Алтанширээ, Өргөн, Иххэт сумдын цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах комисс томилсон байна. Комисс сонгон шалгаруулалтыг зохион байгуулан дүгнэлтийг аймгийн Засаг даргад хүргүүлснээр Алтанширээ, Өргөн сумдын цэцэрлэгийн эрхлэгчийг томилсон байна.

2.1.2. Аймгийн БСУГ-ын ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод хуульд заасан зарим чиг үүрэг тусгагдаагүй байна.

БСШУС-ын 2013 оны А/315 дугаар тушаалаар аймаг нийслэлийн Боловсролын газрын үлгэрчилсэн журам шинэчлэн батлагдсан бөгөөд энэхүү журамд нийцүүлэн журам боловсруулан, мөрдөж ажиллахыг аймаг, нийслэлийн газрын даргад даалгасан. Гэтэл аймгийн БСУГ бүрэн эрх, чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлэх талаар боловсруулсан журам байхгүй байна.

Боловсролын тухай хуулийн 27.2-д Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь аймаг, нийслэлд боловсролын газар, нийслэлийн дүүрэгт боловсролын хэлтэс байна гэж заасан. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага хуульд заасан² чиг үүргийг ажилтны ажлын байрны тодорхойлолтод

² Боловсролын тухай хуулийн 28¹ дугаар зүйлийн 28^{1.1}-д Аймаг, нийслэлийн боловсролын газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 28^{1.1.1}.боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах; 28^{1.1.2}.ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар дүгнэлт

тусгаснаар чиг үүргээ хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, биелэлтийг хариуцах үндэслэл болно.

Аймгийн БСУГ-ын ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод хуульд заасан дараах чиг үүрэг тусгагдаагүй байна.

- Орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойрог тогтоох;
- Орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах

2.1.3. Мэргэжлийн боловсон хүчин дутмагаас СӨБ хариуцах мэргэжилтний ажлыг гэрээгээр гүйцэтгүүлж байна.

“Албан тушаалын тодорхойлолт” гэж тухайн албан тушаалын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын тусгай шаардлагыг баталгаажуулсан баримт бичиг юм. Төрийн албан хаагч нь тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлж, биелэлтийг хариуцан ажиллана.

Орон нутагт сургуулийн өмнөх боловсрол олгох чиг үүргийг хэрэгжүүлж буй байгууллага ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан боловсрол мэргэжил эзэмшсэн хүний нөөцөөр бүрдсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын боловсролын бодлого хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу дээд боловсролтой, бакалвр зэрэгтэй, багш мэргэжилтэй мэргэжилтэн ажиллаж дараах чиг үүргийг тусган хэрэгжүүлж байна.

- Хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутагт хэрэгжүүлэх.
- ТЕЗ-ийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь БСУГ, СӨБ олгох үйл ажиллагааг мэргэшлийн үндсэн дээр удирдан зохион байгуулж, өөрийн эрхэлсэн асуудлын хүрээнд эцсийн шатны зөвлөгөө дэмжлэгээр хангана.
- СӨБ-ын стандарт хангалт, сургалтын үзүүлэлтэд хяналт хийж бодлого боловсруулах
- Хүүхдийн хөгжил төлөвшил тэдэнд эрүүл аюулгүй орчин бүрдүүлэхэд эцэг эх, төр, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах.

БСУГ нийт ажилтны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, журмын дагуу Төрийн албаны зөвлөлд хянуулахаар хүргүүлсэн байна. Тус газарт СӨБ хариуцсан орон тооны ажилтан байхгүй байна.

гаргаж аймаг, нийслэлийн Засаг даргад санал болгох; 28¹.1.3.багш, суралцагчийн хөдөлмөрийг бодитой үнэлж, шагнаж урамшуулах, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх; 28¹.1.4.боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт-шинжилгээ хийх; 28¹.1.5.боловсролын тайлан, мэдээ, мэдээллийг хууль тогтоомжид заасан журмын дагуу холбогдох байгууллагад гаргаж өгөх; 28¹.1.6.орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойрог тогтоох; 28¹.1.7.орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах; 28¹.1.8.төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх. 28¹.1.9.аймаг, дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дүрэмт хувцасны нэгдсэн загварыг батлах. 28¹.1.10.өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах.

БСУГ-ын даргын 2019 оны 2-р сарын 27-ны өдрийн Б/02 дугаар тушаалаар СӨБ хариуцсан мэргэжилтэн үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн байна. Төрийн албаны салбар зөвлөлд сул орон тоо гарсан талаар мэдээлсэн боловч нөөцөд тухайн албан тушаалд тохирох боловсон хүчин бүртгэгдээгүй гэсэн тайлбар өгсөн байна.

Мэргэжлийн боловсон хүчин дутмаг байгаагаас БСУГ-ын сургуулийн өмнөх боловсрол хариуцах төрийн захиргааны албан тушаалын ажлыг 2019 оны 3 сараас эхлэн цэцэрлэгийн арга зүйч гэрээгээр давхар гүйцэтгэж байна.

БСУГ-ын сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтний албан тушаалд сонгон шалгаруулалт зарлаж өгөх хүсэлтийг 6 сарын дараа Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн боловч шийдэгдээгүй байна.

Төрийн албаны салбар зөвлөлөөс СӨБ хариуцах албан тушаалын сул орон тоо нөхөх ажлыг хуулийн³ дагуу шуурхай зохион байгуулаагүйгээс өнөөг хүртэл томилогдсон албан тушаалтан байхгүй, гэрээт ажилтан түр ажиллаж байна.

Иймд сургуулийн өмнөх боловсрол хариуцах албан тушаалтныг хууль журмын дагуу томилж, ажиллах чиг үүргийг тодорхой болгох нь шаардлагатай байна.

БСШУСС-ын 2019 оны А/430 тушаалаар СӨБ-ын байгууллагын ажилтны албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолт баталсан байна. Аудитад хамрагдсан ихэнх цэцэрлэгүүд үлгэрчилсэн журмын дагуу багш нарын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсан байна.

Цэцэрлэгийн багшийн ажлын байрны тодорхойлолтод тавигдах боловсролын шаардлага нь бакалавр түүнээс дээш боловсролын зэрэгтэй СӨБ-ын багш мэргэжилтэй байна гэж заасан. Дорноговь аймгийн цэцэрлэгүүдийн 2016-2017 оны хичээлийн жилд ажилласан багш нарын 78.6 хувь, 2017-2018 оны хичээлийн жилд 85.0 хувь, 2018-2019 оны хичээлийн жилд 82.4 хувь нь диплом болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй, СӨБ-ын багшийн мэргэжил эзэмшсэн байна. *Цэцэрлэгт хамрагдсан хүүхэд, ажилласан багшийн тоог хүснэгт №2-оор харуулав.*

Хүснэгт №2

Хичээлийн жил	Цэцэрлэг тоо	Хамрагдсан хүүхэд				Дүн	Багш, ажилтан		
		цэцэрлэг бүлэг	хүүхэд	Хувилбарт бүлэг	хүүхэд		Үндсэн	Бусад	Нийт
2016-2017	32	144	4774	24	458	5232	164	427	591
2017-2018	33	148	4946	18	408	5354	167	454	621
2018-2019	32	148	4928	16	393	5321	170	454	624

А.2.2 СӨБ-ын санхүүгийн тогтолцоо, чиг үүргийн хуваарилалт оновчтой байна.

2.2.1. Санхүүжилтийг хуульд заасан чиг үүргийн дагуу баталж, хуваарилалт хийсэн байна.

Аймгийн Засаг дарга Төсвийн тухай хуульд заасны дагуу Засгийн газрын сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, соёлын үйлчилгээ, эрүүл мэндийн анхан шатны

³ Төрийн албаны тухай хуулийн 27.1.3.төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоог энэ хуулийн 27.1.2-т заасны дагуу нөхөх боломжгүй бол төрийн албан хаагчийн нөөцөд байгаа иргэдээс; 27.1.4.энэ хуулийн 27.1.3-т заасны дагуу нөхөх боломжгүй бол нээлттэй сонгон шалгаруулалт зарлах.

тусламж үйлчилгээ, хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ, нийтийн биеийн тамир зэрэг чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлж байна.

Төрийн захиргааны төв байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч нь аймгийн Засаг даргатай хуульд заасан дээрх чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ байгуулж, улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлдэг байна.

Аймгийн Засаг дарга нь төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр санхүүжилтийн хуваарилалт хийх саналаа орон нутгийн төсвийн төслийн хамт бэлтгэж аймгийн ИТХ-д өргөн мэдүүлдэг бөгөөд ИТХ нь чиг үүрэг бүрээр хуваарилсан санхүүжилтийг төрийн захиргааны төв байгууллагын шилжүүлсэн нийт хэмжээнээс буруулахгүйгээр орон нутгийн төсвийн нэг хэсэг болгон баталж иржээ.

Боловсролын тухай хуульд⁴ төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагыг тогтмол болон нормативт зардлаар санхүүжүүлнэ, төрийн өмчит ЕБС, цэцэрлэг, дотуур байрны тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал, нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг улсын төсвөөс тус тус санхүүжүүлнэ гэж заасан. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, сургуулийн дотуур байрын тогтмол зардлыг улсын төсвөөс, 2019 оноос эхлэн орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

Сангийн яамнаас тусгай зориулалтын шилжүүллэгийг хуульд заасан сар, улирлын хуваарийн дагуу аймгийн төрийн санд шилжүүлдэг байна.

БСУГ СӨБ-ын байгууллагуудын тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжигдэх төсвийн төсөл, сар улирлын хуваарийг боловсруулж Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлдэг бөгөөд хянан баталгаажуулсан төсөв, хуваарийн дагуу тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийн хуваарийг цэцэрлэгүүдэд хүргүүлдэг байна.

Орон нутагт тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжигдэх хувьсах зардлыг нормативын дагуу олгож байгаа хэдий ч цаашид мөрдөж ажиллахад хүндрэл үүсч байна. Тухайлбал: Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 1650 төгрөгөөр тогтоосон байдаг. Гэтэл 2019-2020 оны хичээлийн жилд махны дундаж үнэ 8000-10000 төгрөгийн ханштай болж, нормативаар тогтоосон 1650 төгрөгийн 65 хувь буюу 1073 төгрөг махны үнэ эзэлж байна. Үнийн өсөлт нь хүүхдийн хоолонд хэрэглэх бүтээгдэхүүний чанар, илчлэг, өдөрт авах шимт бодисын хэмжээнд нөлөөлж, цэцэрлэгүүдэд өр үүсэхэд хүргэж байна.

⁴ Төсвийн тухай хуулийн 40.2.Төрийн өмчит ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрын нийт зардал, тусгай сургуулийн суралцагчийн үдийн хоолны зардал, цэцэрлэгийн байршлыг харгалзан хүүхдийн хоолны зардлын тодорхой хувь, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр ашгийн болон ашгийн төлөө бус цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан болон албан бус сургалтад хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг улсын төсвөөс тус тус санхүүжүүлнэ.

БҮЛЭГ 2**СӨБ олгох бодлогод өөрчлөлт оруулж хэрэгжилтийг үр нөлөөтэй, үр дүнтэй зохион байгуулах хэрэгтэй байна.**

Б.1. СӨБ олгох үйлчилгээний төлөвлөлт хангалтгүй, хүртээмж дутмаг байна.

1.1. СӨБ-ын байгууллагын бодит хэрэгцээ шаардлага их байгаа ч санхүүгийн хязгаарлагдмал нөөцийн хэмжээнд хүн амын нягтаршил, барилгын чанар байдалтай уялдуулан төлөвлөсөн байна.

1.1.1. Цэцэрлэгийн 12 шинэ барилгыг хүн амын нягтаршил, цэцэрлэгийн чанар байдалд уялдуулж төлөвлөсөн байна.

Аймгийн хэмжээнд 2016 оны байдлаар нийт 3720 хүүхдийн хүчин чадал бүхий 33 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд үүнээс 405 хүүхдийн хүчин чадал бүхий хувийн өмчийн 4 цэцэрлэг байна.

Судалгаа №3 Хүн ам, цэцэрлэгийн насны хүүхдийн тоо болон хүчин чадлын хамаарал, төлөвлөсөн барилга, хэрэгжилтийн судалгаа

	Сумдын нэр	Цэцэрлэгийн барилгын ашиглалтад орсон он	2016 оны статистик мэдээгээр					Шинээр шаардлагатай цэцэрлэгийн хүчин чадал	Мөрийн хөтөлбөрт тусгасан шинэ барилгын болон өргөтгөлийн барилгын тоо	Хэрэгжсэн цэцэрлэгийн	
			Хүн амын тоо	Өрхийн тоо	Цэцэрлэгийн хүчин чадал	Төмөр замын цэцэрлэгийн хүчин чадал	Цэцэрлэгийн насны хүүхдийн тоо			тоо	Хүчин чадал
А	Б		1	2	3	4	5	6/5-3-4	7	8	9
1	Айраг	2012	3738	1184	175	90	341	76			
2	Алтанширээ	1987	1294	450	50		115	65	1		
3	Даланжаргалан	2011	2742	930	150	50	262	62	1	1	75
4	Дэлгэрэх	2015	1889	551	75		168	93			
5	Иххэт	1983	2077	708	150		174	24			
6	Мандах	1977	1568	492	75		131	56	1		
7	Өргөн	1990	1933	676	100		171	71		1	100
8	Сайхандулаан	2012	1367	461	50		132	82			
9	Улаанбадрах	2008	1474	502	75		131	56			
10	Хатанбулаг	2013	2941	932	150		260	110			
11	Хөвсгөл	2012	1568	486	75		135	60			
12	Эрдэнэ	2008	2437	785	75	25	218	118			
13	Сайншанд	1957-2015	24059	7195	1515	125	2425	785	5	2	175
14	Замын-Үүд	2001-2015	17519	4947	1005	240	1892	647	4	2	150
	Дүн		66606	20299	3720	530	6555	2305	12	6	500

Судалгаа № 3-ын дүнгээс үзэхэд 2016 оны байдлаар бүх сумдад цэцэрлэгийн барилга барих шаардлагатай байна. Тухайлбал: Нийт 2305 хүүхдийн хүчин чадал бүхий буюу 150 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг гэж тооцоход 15 цэцэрлэг, 100 хүүхдийн хүчин чадалтай гэж тооцоход 23 цэцэрлэг хэрэгтэй гэсэн тооцоо гарч байна.

Аудитын явцад хийсэн судалгаанаас хүн амын нягтаршил, хэрэгцээт хүчин чадлын тооцооллыг эрэмбэлвэл Хатанбулаг, Эрдэнэ сум тус бүрт 100-аас дээш хүчин чадал бүхий 1 цэцэрлэгийн барилга, Сайншанд, Замын-Үүд сум тус бүрт

100- 150 хүүхдийн хүчин чадал бүхий 6 цэцэрлэгийн барилга барих тооцоо гарч байна. /Аймгийн ХБХ, ГХБХБГ Дорноговь аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй сургууль, цэцэрлэгүүдийн хүчин чадал болон шаардагдаж буй эрэлт хэрэгцээ, шинээр барих шаардлагатай сургууль, цэцэрлэг, цэцэрлэгүүдийн хүүхдийн тоо болон хүчин чадлын хамаарал зэргийг 2016 оны байдлаар судалж графикаар гаргасан байв./

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Хөгжлийн төлөө хамтдаа” /2016-2020 он/ хөтөлбөрт “Алтанширээ, Даланжаргалан сумын Олон-Овоо баг, Мандах, Замын-Үүд, Сайншанд сумын 1,5,6-р багуудад цэцэрлэгийн барилгыг шинээр барих, Сайншанд сумын 5, 8-р цэцэрлэг, Замын-Үүд сумын 1-р цэцэрлэгийн барилгыг өргөтгөн барьж, сумдын хүүхдийн цэцэрлэгийн барилгад их засвар хийж, хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан СӨБ-ын үйлчилгээнд хамруулахыг дэмжинэ” хэмээн тусгасан байна. /Мөрийн хөтөлбөрт тусгасан зорилтын хүрээнд ТАХ-г хэрэгжүүлж байгаа тул төлөвлөлтийг 2016 оноор тооцсон болно./

СӨБ-ын байгууллагын бодит хэрэгцээ шаардлага бүх суманд байсан хэдий ч /15-23 цэцэрлэг барих/ санхүүгийн хязгаарлагдмал нөөцөөс хамаарч хүн амын нягтаршил, чанар байдалтай нь уялдуулан 2016-2020 онд шинээр барих цэцэрлэгийн барилгыг 12-оор төлөвлөжээ. Тухайлбал: Судалгааны дүнгээр Хатанбулаг, Эрдэнэ суманд 100-аас дээш хүүхдийн хүчин чадал бүхий цэцэрлэгийн барилга барих зайлшгүй шаардлагатай байсан ч тус сумдад шинээр барих цэцэрлэгийг төлөвлөөгүй, харин барилгын чанар /ашиглагдаад 29-39 жил болсон/ байдалтай нь уялдуулан 50-аас дээш хүүхдийн хүчин чадал бүхий 2 цэцэрлэгийг Мандах, Алтанширээ сумдад барихаар төлөвлөжээ.

1.1.2.Цэцэрлэгийн барилгын хүчин чадлыг тодорхойлоход санхүүжилтийн эх үүсвэрийн хэмжээ нөлөөлж байна.

МУ-ын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт 6502.4 сая төгрөгийн СӨБ-ын шинэ барилга болон барилга засварын ажил хийгджээ.

Аудитын хамрагдах хугацаанд цэцэрлэгийн 6 барилга шинээр ашиглалтад орсон байна. Тухайлбал:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар: Сайншанд суманд улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд орон сууцны барилгатай хамт баригдсан 100 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгыг худалдаж авсан байна. Замын-Үүд суманд 2018 онд улсын төсвийн хөрөнгөөр 100 хүүхдийн хүчин чадал бүхий цэцэрлэгийн 1 барилгыг /орон сууцны барилгатай хамт барьсан/ худалдаж авсан.

Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр: Өргөн суманд 2016 онд Япон улсын Өвсний үндэс төслийн санхүүжилтээр 100 хүүхдийн хүчин чадал бүхий цэцэрлэгийн барилга ашиглалтад орсон байна. Замын-Үүд суманд 2017 онд АНУ-ын буцалтгүй тусламжаар 50 хүүхдийн хүчин чадал бүхий цэцэрлэгийн барилга ашиглалтад орсон байна.

Дотоодын байгууллагуудын нийгмийн хариуцлагын хүрээнд үзүүлсэн тусламж хандиваар: Даланжаргалан сумын Олон-Овоо багт 2018 онд Френдшип ХХК-ийн хөрөнгө оруулалтаар 75 хүүхдийн хүчин чадал бүхий /сумын цэцэрлэгийн салбар/ цэцэрлэгийн барилга ашиглалтад орсон байна. Сайншанд сумын Зүүнбаян багт газрын тосны Доншень ХХК-ийн хөрөнгө оруулалтаар 75 хүүхдийн хүчин чадал бүхий цэцэрлэгийн барилга 2018 онд ашиглалтад орсон.

Цэцэрлэгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага, санхүүжүүлэх эх үүсвэр дутагдалтай асуудлыг шийдвэрлэхэд гадаад, дотоодын байгууллагын дэмжлэг туслалцаа их хувь нэмэр оруулсан байна.

Төсөв хөрөнгийн эх үүсвэрээс хамаарч шаардлагатай хүчин чадлын дагуу цэцэрлэгийн барилгыг төлөвлөж, хэрэгжүүлээгүй байна. Харин ашиглалтад орсон цэцэрлэгүүдийн анги танхимыг зориулалтын дагуу ашигласан байна.

1.1.3.Хүүхдийн аюулгүй байдал, орчны стандарт бүрэн хангагдаагүй байна.

Боловсролын тухай хуулийн 42.1-д “Боловсролын сургалтын байгууллагын барилга, байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна” гэж заасан. Мөн БСШУСС-ын тушаалаар баталсан “Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм”-д цэцэрлэг нь гадаад орчин, гэрэлтүүлэг, замын гарц, хурд сааруулагч, зогсоол зэргийг замын хөдөлгөөний аюулгүй байдалд бүрэн нийцүүлж, сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгслийн бүрэн бүтэн байдал, ашиглалт, хадгалалт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан байна гэж заасан.

Тайлант хугацаанд шинээр ашиглалтад хүлээн авсан барилгуудын орчны стандарт хангасан байдлыг авч үзвэл: Сайншанд сумын 13-р цэцэрлэг /шинээр худалдаж авсан/: Орчны стандартыг бүрэн хангаагүй байна. Гэрэлтүүлэг, камер, биеийн тамирын талбай, элсэн талбай, сүүдрэвч, хөгжим, биеийн тамирын танхим, ус нөөцлөх сав, хог хаягдлын зориулалтын сав байхгүй, ундны болон ахуйн усанд хийсэн эрүүл ахуйн шинжилгээгээр шаардлага хангаагүй гарсан. Тээврийн хэрэгслийн зогсоолын талбайтай, хашлагатай боловч тэмдэг, тэмдэглэгээ байхгүй байна.

Замын-Үүд сумын 6-р цэцэрлэг /шинээр худалдаж авсан/: Цэцэрлэгт биеийн тамирын талбай, бүлгүүдэд эмнэлгийн тусламжийн иж бүрдэл, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүн, хөгжим, биеийн тамирын танхим байхгүй байна.

Өргөн сумын цэцэрлэг /Япон улсын Өвсний үндэс төслийн санхүүжилтээр/: Орчны стандартыг бүрэн хангаагүй байна. Үүнд: Камер, биеийн тамирын талбай, хөгжим, биеийн тамирын танхимтай ч хэрэглэгдэхүүн байхгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүн байхгүй. 2-3 настай хүүхдийн суултуурын өндөр нь стандартад заасан хэмжээнээс 10 смээр өндөр тул хөл дор нь тавиур тавьдаг.

Замын-Үүд сумын 5-р цэцэрлэг /АНУ-ын тусламжийн хөрөнгөөр/: Тус цэцэрлэгийн сургалтын 1 танхимд ахлах, бэлтгэл бүлгийн хүүхдүүдийг хамт хичээллүүлж байна. Цэцэрлэгт камер, биеийн тамирын талбай, элсэн талбай, хөгжим, биеийн тамирын танхим, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүн байхгүй байна.

Даланжаргалан сумын Олон-Овоо багт байрлах 75 хүүхдийн хүчин чадал бүхий салбар цэцэрлэг /Френдшип ХХК-ийн хөрөнгө оруулалтаар /: Орчны стандартыг бүрэн хангаагүй байна. Тухайлбал: Тоглоомын болон биеийн тамирын талбай байхгүй, элсэн талбайгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүн байхгүй байна.

Сайншанд сумын Зүүнбаян багт газрын тосны Доншень ХХК-ийн хөрөнгө оруулалтаар 75 хүүхдийн хүчин чадал бүхий салбар цэцэрлэг: Тус цэцэрлэг хашаагүй, гадна гэрэлтүүлэг байхгүй, тоглоомын болон биеийн тамирын талбайгүй, авто машины зогсоолын талбайд тэмдэг тэмдэглэгээгүй, сүүдрэвч байхгүй, барилгад дохиоллын систем байхгүй байна.

Аудитад хамрагдсан Ухаалаг багачууд хувийн өмчийн цэцэрлэгийн гадаах талбайг тохижуулаагүй, камер нь ажиллаагүй, замын тэмдэг, тэмдэглэгээ байхгүй байна.

Аймгийн нийт цэцэрлэгүүдэд 2018 оны байдлаар 343 камер ашиглагдаж байсан бол 2019 онд 379 камертай болж 36-аар нэмэгдүүлсэн байна. Энэ нь нийт цэцэрлэгүүдийн камерийн хэрэгцээний 69.3 хувь хангагдсан байх ба бүх цэцэрлэгүүдийг 100 хувь хангахад 168 камер зайлшгүй шаардлагатай байна. Цэцэрлэгүүдийн гадаах гэрэлтүүлэг, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай хэмжээнд бүрэн хангаагүй байна.

Б.1.2. Орон нутгийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд СӨБ-ын байгууллагын хэрэгцээг тусгасан байна.

1.2.1. Газар олголт, барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлжээ.

Замын-Үүд сум 2030 он хүртэлх хот байгуулалтын төлөвлөгөөг 2011 онд батлуулж, 2019 онд 57 га талбайд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг нийслэлийн хот байгуулалтын хүрээлэнгээр гүйцэтгүүлж байгаа бөгөөд эдгээр ерөнхий төлөвлөгөөнүүдэд бүсчлэлийн дагуу цэцэрлэгийн барилгыг тусган төлөвлөсөн байна.

Аймгийн хэмжээнд шинээр баригдсан барилгын газар олголт, барилга угсралтын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн /хүснэгт 3/ байна.

Хүснэгт №4 Газар болон барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон шийдвэрийн судалгаа

	Байршил, хүчин чадал	Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн огноо, дугаар	Газар олгосон шийдвэр	Аймаг, сумын ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан эсэх
1	Өргөн сумын 100 хүүхдийн цэцэрлэг	БУ-06/2016 05/16/2016	2012.08.29 А/102	Сумын ИТХ-ын 2012 оны 22 дугаар тогтоол, СХТ-тэй уялдсан
2	Замын-Үүд сумын 50 хүүхдийн цэцэрлэг	БУ-06/2017 04/21/2017	2017.03.21 А/71	Сумын ИТХ-ын 2016 оны 17 дугаар тогтоол СХТ-тэй уялдсан
3	Сайншанд сумын 3-р багт 100 хүүхдийн цэцэрлэг	БУ-53/2017 09/18/2017	2018.11.29 А/825	Сумын ИТХ-ын 2016 оны 02 дугаар тогтоол, СХТ-тэй уялдсан
4	Замын-Үүд сумын 100 хүүхдийн цэцэрлэг	БУ-54/2017 09/18/2017	2018.12.31 А/475	Орон сууцны хороололд, СХТ-тэй уялдсан
5	Даланжаргалан сумын Олон-Овоо багийн 75 хүүхдийн цэцэрлэг	БА3-БУ-31/2018 06/08/2018	2018.06.13 А/77	Сумын ИТХ-ын 2018 оны 09/03 дугаар Даланжаргалан сумын хөгжлийн төлөвлөгөө батлагдаагүй
6	Сайншанд сумын 5-р багт 50 хүүхдийн цэцэрлэг	БА3-БУ-59/2018 08/15/2018	2018.06.06 А/193	Сумын ИТХ-ын 2018 оны 10 дугаар тогтоол, СХТ-тэй уялдсан

Аудитын хугацаанд аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө байгаа эсэх, шинээр барих барилгуудыг тус төлөвлөгөөтэй уялдуулсан эсэх талаар аудитын асуулга боловсруулж хариу авахаар хүргүүлсэн боловч ГХБХБГазар, аймгийн ЗДТГ-ын ХБТХэлтэсээс нотлох баримт, тайлбарыг ирүүлээгүй болно.

Б.1.3. Цэцэрлэгт хамрагдвал зохих бүх насны хүүхэд СӨБ олгох үйлчилгээнд бүрэн хамрагдаж чадахгүй байна.

3.1.1. Аймгийн хэмжээнд СӨБ олгох үйлчилгээнд 464-602 хүүхэд хамрагдаагүй байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийг хэрэгжүүлж, хот суурин газарт хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах боломжийг бий болгоно гэж тусгасан.

Дорноговь аймгийн СӨБ-ын сүүлийн 3 хичээлийн жилийн байдлаарх статистик мэдээнээс харахад СӨБ-д хамрагдаагүй хүүхэд 464-602 байна.

Хүснэгт №5 Цэцэрлэгт хамрагдах болон хамрагдсан хүүхдийн статистик судалгаа

	Үзүүлэлт	2016-2017	2017-2018	2018-2019
1	СӨБ-д хамрагдвал зохих хүүхдийн тоо	6555	6799	6779
2	СӨБ-д хамрагдаж байгаа хүүхдийн тоо	5232	5354	5321
3	Үүнээс хувилбарт сургалтад хамрагдсан хүүхдийн тоо	458	408	393
4	Төмөр замын цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдийн тоо	859	907	856
5	Цэцэрлэгт хамрагдаж байгаа нийт хүүхдийн тоо	6091	6261	6177
6	СӨБ-д хамрагдаагүй хүүхэд	464	538	602
7	Хамран сургалтын хувь	92.9	92.1	91.1

Хүн амын өсөлт хурдацтай явагдаж байгаагаас шалтгаалан хамран сургалтын хувь жил бүр буурсан үзүүлэлттэй гарсан байна. Хувилбарт сургалтанд 393-458 хүүхэд хамрагдсан байх ба сумдын цэцэрлэгүүд хувилбарт сургалтыг 6-8 дугаар саруудад, 10-14 хоногийн хугацаатай явуулж иржээ.

Аймгийн хэмжээнд зөвхөн Замын-Үүд суманд хувийн өмчийн 4 цэцэрлэг СӨБ олгох үйл ажиллагааг явуулдаг бөгөөд тус цэцэрлэгүүдийн хамрагдалтыг хүснэгт №6-д авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт №6 Хувийн өмчийн цэцэрлэгийн хүчин чадал, хамрагдалтын судалгаа

№	Замын-Үүд сумын хувийн цэцэрлэгийн нэр	Цэцэрлэгийн хүчин чадал	2015-2016 он	2016-2017 он	2017-2018 он	2018-2019 он	Цэцэрлэгийн нэг хүүхдээс авах сарын төлбөр
1	Гурванбилэг	35	27	31	30	33	1-2 настай 150.0 мян/төг, 2-5 настай 120.0 мян/төг
2	Жаргалан	100	92	109	102	109	1,5-2 настай 150.0 мян/төг, 2-5 настай 100.0 мян/төг
3	Болор-Эрдэнэ	100	104	90	113	0	1,5-2 настай 150.0 мян/төг, 1-5 настай 100.0 мян/төг
4	Ухаалаг багачууд	150	114	105	105	92	1,5-4 настай 130.0 мян/төг, 4-5 настай 100.0 мян/төг
	Дүн	385	337	335	350	234	

Замын-Үүд суманд сүүлийн 3 жилийн байдлаар 3 цэцэрлэг шинээр ашиглалтад орсон байна. Тус хувийн цэцэрлэгүүдэд мэргэжлийн бус багш нар ажилладаг, төлбөртэй үйл ажиллагаа явуулдаг зэрэг шалтгаанаар хувийн өмчийн цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоо цөөрч дийлэнхдээ яслийн насны хүүхдүүд хамрагддаг байна.

Сүүлийн жилүүдэд СӨБ-ын байгууллагын тоо нэмэгдэж, шинээр цэцэрлэгүүд ашиглалтад орсоор байгаа ч хамран сургалтын хувь жил бүр буурсан үзүүлэлттэй байгаа нь малчид, хилийн заставын албан хаагчид, төмөр замын өртөө, шугам замын ажиллагсад зэрэг иргэдийн хүүхдүүд мөн амьжиргааны түвшин доогуур айл өрхийн хүүхдүүд, хүүхдээ гэрээр асран хамгаалах хүнтэй айл өрхийн 2-4 насны хүүхдүүд цэцэрлэгт хамрагдаагүй байна.

3.1.2. Хувийн өмчийн цэцэрлэгүүдийн багш нарт хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж олгогдоогүй байна.

Тус аймаг дахь хувийн өмчийн цэцэрлэгүүдээс Ухаалаг багачууд цэцэрлэгийг аудитад хамруулсан бөгөөд тус цэцэрлэгт 2016 онд 97.4 сая төгрөг, 2017 онд 98.4 сая төгрөг, 2018 онд 98.3 сая төгрөгийн төсөв батлагдаж, санхүүжилтийг бүрэн олгосон байна. Ухаалаг багачууд цэцэрлэгийн 2018 оны төсөвт бараа, үйлчилгээний зардал 1.3 сая төгрөгөөр батлагдсанаас хичээл, үйлдвэрлэлийн зардалд 1.0 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 0.2 сая төгрөг, томилолтын зардалд 0.1 сая төгрөг тус тус батлагджээ.

Тус цэцэрлэг нь эрхлэгч 1, бүлгийн багш 3, туслах багш 2, тогооч, нярав, сантехникч тус бүр 1, галч манаач 3, нийт 12 ажиллагсадтайгаар 3 бүлэгт үйл ажиллагаагаа явуулжээ.

МУ-ын Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7-д заасан “Багш нарт 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний тэтгэмжийг улсын төсвөөс ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулж олгоно”, 43.3-т “Багш, суралцагчид үзүүлэх хөнгөлөлт, нөхөх олговор, тэтгэлэг, тэтгэмж, шагнал урамшил нь өмчийн хэлбэр харгалзахгүй адил тэгш байна” гэж заасан боловч эдгээр заалт хувийн өмчийн цэцэрлэгийн багш нарт хэрэгжээгүй байна.

Хувийн өмчийн Ухаалаг багачууд цэцэрлэгт 2016 онд 97.4 сая төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 89.8 сая төгрөгийн цалингийн зардал, НДШ-ийн зардалд 9.5, бараа үйлчилгээний бусад зардалд 1.3 сая төгрөг зарцуулжээ. Цалингаас суутгасан ХХОАТ-ын 3.2 сая төгрөгийн өр үүсэн байв. Энэхүү нөхцөл байдлыг харахад хүүхдийн тооны нормативаар төсвийг тооцож, хуваарилж буй нь бодитой бус байгааг илтгэн харуулж байна. Мөн төсвийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалж хувийн өмчийн цэцэрлэгийн багш нар хуулиар заасан тэтгэмжийг авч чадахгүйд хүрчээ.

Б.1.4. СӨБ-ын хөтөлбөрийн хэрэгжилт хангалттай бус байна.

4.1.1. Хүчин чадлаас давсан анги дүүргэлт нь хүүхдүүдэд насан туршийн боловсролын суурь чадварыг бүрэн эзэмшүүлэх үйл ажиллагааны үр дүнг бууруулах эрсдэлтэй байна.

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулиар “СӨБ-ын зорилгыг бага насны хүүхдийг өөрийн онцлог чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх” гэж тодорхойлсон.

Аудитад хамрагдсан цэцэрлэгүүдийн хүчин чадлыг сүүлийн гурван жилд цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн 3 жилийн дундаж тоотой харьцуулахад Сайншанд сумын 9-р цэцэрлэг 126 хүүхдээр, Замын-Үүд сумын 3-р цэцэрлэг 90 хүүхдээр хүчин чадлаасаа илүү ачаалалтай ажилласан бол аймагт хамгийн ойр байрладаг Сайхандулаан сумын цэцэрлэг хүчин чадлаараа ажилласан байна.

Хүснэгт №7 Хүчин чадлаас давсан хүүхэд, нэг багшид ногдох хүүхдийн тооны судалгаа

Цэцэрлэгийн нэр	Хүчин чадал	2015-2016 онд Хамрагдсан хүүхэд	2016-2017 онд хамрагдсан хүүхэд	2017-2018 онд хамрагдсан хүүхэд	Цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүдийн 3 жилийн дундаж	Хүчин чадлаас давсан хүүхдийн дундаж	Бүлгийн тоо	Нэг багшид ногдох хүүхдийн тоо
Сайншанд 1-р цэцэрлэг	100	132	120	123	125	25	4	31
Сайншанд 2-р цэцэрлэг	150	212	212	206	210	60	6	35
Сайншанд 9-р цэцэрлэг	150	296	270	262	276	126	6	46
Сайншанд 11-р цэцэрлэг	175	176	187	193	185	10	7	26
Сайншанд 12-р цэцэрлэг	150	128	212	219	186	36	6	31
Замын-Үүд 3-р цэцэрлэг	200	273	294	305	290	90	8	36
Замын-Үүд 5-р цэцэрлэг	50	0	0	89	89	39	3	29
Сайхандулаан сумын цэцэрлэг	50	51	49	53	51	1	2	25

Цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэмд тусгаснаар нэг багшид 20-25 хүүхэд ногдох байтал Хүснэгт № 7-гийн дүнгээс харахад Сайншанд сумын 11-р цэцэрлэг, Сайхандулаан сумын цэцэрлэгээс бусад 6 цэцэрлэгт нэг багшид 29-46 хүүхэд ногдож, цэцэрлэгийн хүчин чадлаас давсан хүүхэдтэй байгаа нь хүүхэд бүрт хүрэх сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай, багшийн хүртээмж багасч, сургалтын чанар буурах, “хүүхдүүдэд насан туршийн суурь чадвар эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх” гэсэн зорилго хангагдахгүй байх эрсдэл бий болж байна.

БСШУСС-ын 2019 оны А/118 дугаар тушаалаар баталсан “Цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 2.8-д “Цэцэрлэг нь хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн бүлгийн хүүхдүүдтэй хамт сургах тохиолдолд хүүхдийн хөгжлийн бэрхшээлд тохирсон ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Замын-Үүд сумын 4-р цэцэрлэгт 2017, 2018 онд хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүлэг хичээллэж байсан бөгөөд 2019 оноос дээрх бүлгийн хүүхдүүдийг ердийн бүлэгт хуваарилан өгч, бүлгийн өрөөг ердийн анги болгосон байна.

Сайншанд сумын 11 дүгээр цэцэрлэгийн ердийн бүлэгт хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 4 хүүхэд суралцаж байгаа ба 2015 оноос тусгай хэрэгцээт боловсролын бүлэг байгуулж, тус бүлэгт 2019 оны байдлаар 17 хүүхэд хамрагдсаны 2-5 насны 11 хүүхэд, 6-10 насны 6 хүүхэд байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүгнэлтээр тус хүүхдүүдийг тархины саажилттай, сэтгэцийн үйл ажиллагааны болон үе мөчний хоцрогдолтой, бүрэн харааны бэрхшээлтэй, байнгын асаргаа шаардлагатай болохыг тодорхойлжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах тусгай мэргэжлийн багш, боловсон хүчин байхгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом байхгүй, зөвхөн эцэг эхээс болон нийгмийн халамжийн түншлэлийн хүрээнд хүүхэд тоглуулж саатуулах цөөн тооны хэрэгсэл, тэргэнцэрүүдийг бэлтгэсэн байна. Тус бүлгийн багш тусгай боловсролын сургалтад хамрагдсан ч хүүхдүүдийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалан хүүхдүүдэд сургалтын хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа явуулах боломжгүй, хүүхдүүд ч СӨБ-оор насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмших боломжгүй байна.

4.1.2.Төрийн болон хувийн өмчийн цэцэрлэгийн сургалтын чанарын түвшин жигд бус байна.

Цэцэрлэгүүд сургалтын хөтөлбөр, агуулгын дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа хэдий ч хөтөлбөрийн дагуу хэрэглэгдэх хичээлийн хэрэглэгдэхүүний төсөв хүрэлцээгүйгээс тухайн чиглэлээр хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэхэд учир дутагдалтай байна.

Хүүхдийн хөгжлийн чадвар, чадамж, хөгжлийн ахицыг үнэлэх, хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа явуулахад дараах хичээлийн хэрэглэгдэхүүн зайлшгүй шаардлагатай болдог. Тухайлбал: Хөдөлгөөн эрүүл мэндийн хичээлийн чиглэлээр цагираг, бөмбөг, налуу шат, савлуур, дээс, шагай гэх мэт, хэл ярианы чадамж хичээлийн чиглэлээр байгалийн дуу чимээ, амьтны дуу авиаг сонсох

төхөөрөмж гэх мэт, хөгжмийн чадамж чиглэлээр хөгжмийн зэмсэг, бөмбөр, шагшуур гэх мэт хэрэглэгдэхүүн шаардлагатай болдог байна. Аудитад хамрагдсан 8 цэцэрлэгээс Сайншанд сумын 12 дугаар цэцэрлэгт налуу шат байсан бөгөөд бусад цэцэрлэгт байхгүй байна. Энэ нь хүүхэд налуу шатанд авирч, буух хөдөлгөөний чадвар хэрхэн дээшилснийг үнэлэх боломжгүйг харуулж байна.

Хувийн өмчийн цэцэрлэгт мэргэжлийн бус багш нар ажиллаж байгаа, хичээлийн хэрэглэгдэхүүний хүрэлцээ дутмаг тул цэцэрлэгийн хүүхдийн сургалтын чанар төрийн цэцэрлэгийн хүүхдийн сургалтын чанараас доогуур байдаг тухай БСУГ-ын мэрэгжилтэн тайлбар өгсөн болно.

4.3. Сургалтын хөтөлбөрийн агуулга өргөн цар хүрээтэй, бүртгэл, судалгаа, тайлагнах ажил их байгаа нь хүүхдэд СӨБ эзэмшүүлэх хүртээмжийг бууруулж байна.

БСШУС, НХХС, СС-ын хамтарсан 2007 оны 307/91/237 дугаар тушаалаар баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам”-д цэцэрлэгийн багшийн ажил нь сургуулийн өмнөх боловсролын стандартыг хэрэгжүүлэх ажил болон бусад ажил гэсэн үндсэн 2 үйл ажиллагаатай байна.

Стандартыг хэрэгжүүлэх ажил нь сургалтын хөтөлбөр төлөвлөн боловсруулах, сургалтын хөтөлбөрийн дагуу хичээл заах, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх гэсэн 3 үе шатны ажил хэрэгжүүлэх бол бусад ажилд сургалтын үйл ажиллагааг дэмжих, багшийн хөгжлийг хангах, иргэд, суралцагчидтай ажиллах гэсэн 3 төрлийн үйл ажиллагаа багтахар заасан байна. Цэцэрлэгийн багш 7 хоногт ажлын 40 цагтай тэнцэх стандартыг хэрэгжүүлж, бусад ажлыг гүйцэтгэнэ гэжээ.

Цэцэрлэгүүдийн өдрийн дэглэмд өглөө 7 цаг 30 минутаас оройны 17 цаг 30 минут хүртэл нэг өдөрт 10 цаг, долоо хоногт 50 цаг зарцуулахаар /хүснэгт 8/ тусгасан байна.

Хүснэгт № 8 Өдрийн дэглэмийн хуваарь

	Үзүүлэлт	Сайншанд 9-р цэцэрлэг	Сайншанд 12-р цэцэрлэг	Замын-Үүд 3-р цэцэрлэг	Замын-Үүд 5-р цэцэрлэг
1	Өглөөний хүлээн авалт	07.30-08.10	07.30-08.30	07.30-08.00	07.30-08.10
2	Тойргийн цаг, өглөөний цай	08.40-10.00	08.30-09.20	08.00-09.30	08.10-09.50
3	Сургалтын үйл ажиллагаа /хичээл/	10.00-11.00	09.20-11.00	09.30-10.25	09.50-11.00
4	Туслах багшийн цаг				11.00-11.40
5	Чөлөөт цаг /тоглох, өөртөө үйлчлэх/	11.00-12.00	11.00-12.00	10.25-12.00	11.40-12.00
6	Өдрийн хоол	12.00-13.20	12.00-13.00	12.00-13.00	12.00-13.00
7	Өдрийн амралт /унтлага/	13.20-15.20	13.00-15.30	13.00-15.30	13.00-15.00
8	Хөдөлгөөн чийрэгжүүлэлт, цайны цаг	15.20-16.00	15.30-15.50	15.30-16.30	15.00-15.50
9	Чөлөөт үйл ажиллагаа, таралт	16.00-17.30	15.50-17.30	16.30-17.30	15.50-17.30

БСШУСС-ын 2005 оны А/118 дугаар тушаалаар баталсан Цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийн 3.4-т “Цэцэрлэгийн эрхлэгч нь нэг өдрийн ажлын цагт багтаан багш нартаа дараа өдрийн хичээл, үйл ажиллагааг зохион байгуулахад бэлтгэх 1-2 цагийн зохицуулалт хийж өгнө” гэсэн заалтын дагуу Замын-Үүд сумын 5-р цэцэрлэг өдрийн дэглэмдээ туслах багшийн цагийг тусгаж өгсөн байна.

Өдрийн дэглэмээс харахад өдөр тутмын тогтмол явагддаг үйл ажиллагаа буюу хүүхэд хүлээн авах, өглөөний цай, өглөөний дасгал, эрүүл ахуй, ариун цэвэр, хооллолт, нойрсолт, хувцаслалтад нийт хугацааны 90-ээд хувийг зарцуулсан байна. Стандартын дагуу гүйцэтгэх сургалтын үйл ажиллагаа буюу хөдөлгөөн, эрүүл мэнд, зан чанар, харилцаа, хэл яриа, математикийн энгийн төсөөлөл, хүрээлэн буй орчин, хөгжим, дүрслэх урлаг гэсэн чиглэлээр нийт хугацааны 10-аад хувийг зарцуулсан байгаа ч цэцэрлэгийн багшийн хүүхэдтэй ажиллах нийт хугацааг хүүхэд хөгжүүлэх цаг хэмээн үздэг байна.

Цэцэрлэгийн сургалтын цөм хөтөлбөрийн агуулга өргөн хүрээтэй, олон нэр төрлийн бүртгэл судалгааг сар бүр боловсруулан гаргадаг, нэг багшид ногдох хүүхдийн тоо стандарт хамжээнээс давсан зэрэг ачаалалтай байдлаас шалтгаалан хүүхэдтэй ажиллах цагийг бууруулж байгаа ба өдрийн дэглэмд тусгагдаагүй ажлуудыг багш ажлын бус цагаар хийх нөхцөл үүсдэг байна.

Б.2. СӨБ олгох үйл ажиллагаа нь мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдаагүй байна.

2.1. СӨБ-ын байгууллагад хүний нөөцийн хүрэлцээ дутмаг байна.

2.1.1. Нэг багшид ногдох хүүхдийн тоо 15-20 хүүхдээр илүү байна.

БСШУСС-ын 2019 оны А/118 дугаар тушаалаар баталсан Цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийн 2.6-д “цэцэрлэгийн бага бүлгийг дунджаар 20, дунд, ахлах, бэлтгэл бүлгийг дунджаар 25, холимог бүлгийг дунджаар 20 хүүхэдтэй, яслийн бүлэгтэй бол 15 хүүхэдтэйгээр зохион байгуулна” гэж тусгасан. Гэтэл хүн амын нягтрал, шилжилт хөдөлгөөнөөс хамааран Замын-Үүд, Сайншанд сумдад цэцэрлэгийн барилгууд шинээр баригдаж, СӨБ олгох үйл ажиллагаагаа явуулж байгаа ч цэцэрлэгт явах хүүхдийн тоо жилээс жилд нэмэгдэж, нэг багшид дунджаар 35-40 хүүхэд оногдож байна.


Нэг багшид ногдох хүүхдийн тоо 15-20 хүүхдээр илүү байгаа нь хүүхэд бүрийг ажиглах, хөгжүүлэх, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, өдрийн дэглэмийг мөрдөх, хүүхдийн хувийн хэрэг хөтлөх, мэдээ тайлан гаргах зэрэг ажлыг гүйцэтгэхэд хүндрэлтэй болгож, багш нарын ажлын ачааллыг нэмэгдүүлдэг байна. Мөн ээлжийн багш ажиллуулах орон тоо, төсөв батлагддаггүйгээс ажлын цагийг зохистой ашиглах, хүүхдийн насан туршийн боловсролын суурь чадвар эзэмшүүлэх зорилгын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

2.1.2. Багш, ажилчдад тэтгэмж урамшууллыг бүрэн олгосон ч ур чадварын нэмэгдэл, илүү цагаар ажилласны хөлсөө зарим багш, ажиллагсад авч чадахгүй байна.

Боловсролын тухай хуулийн 43.1.4-т “... 25 ба түүнээс дээш жил ажилласан иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгоход түүний үндсэн цалингаар тооцож нэг удаагийн

буцалтгүй мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас нь олгох бөгөөд шаардагдах зардлыг нь тухайн жилийн төсөвт тусгах” гэж заасан байна. Тэтгэмжийг 2016 онд 6 багш, 4 ажилтан, 2017 онд 5 багш, 7 ажилтан, 2018 онд 3 багш, 3 ажилтан /дүрслэл 1/ тус тус авсан байна.

Дүрслэл №1 Тэтгэвэр тогтоолгоход авсан тэтгэмжийн судалгаа



Боловсролын тухай хуулийн 43.1.7-д “... 5 жил тутам нэг удаа 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгох” гэсэн заалтын хүрээнд: 2016 онд 12 багшид 35641.4 мянган төгрөг, 2017 онд 41 багшид 143146.2 мянган төгрөг, 2018 онд 71 багшид 213477.8 сая төгрөг тус тус олгожээ.

БСШУС-ын 2013 оны А/293 дугаар тушаалаар баталсан “Цэцэрлэгийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам”-д багшийн ажлыг төлөвшил, хүүхэд бүрийн онцлогийн илрүүлэлт, хүүхэд бүрийн хөгжлийн ахиц, боловсролын үйлчилгээний сэтгэл ханамж, эрүүл мэндийн байдал гэсэн 5 нийтлэг шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэхээр заасан.

Аудитад хамрагдсан цэцэрлэгүүдийн багш нарын ажлын тайлан, гүйцэтгэлийн үнэлгээг харахад ажлын гүйцэтгэл нь зарим шалгуур үзүүлэлтэд хамаарахгүй байхад тухайн үзүүлэлтийн оноог бүрэн өгч үнэлсэн байна. Тухайлбал: Хүүхэд бүрийн онцлогийн илрүүлэлт гэсэн шалгуур үзүүлэлтэд бүх цэцэрлэгүүдийн бүлгийн багш хүүхэд тус бүрийн онцлог, давуу болон сул талыг судалсан, хүсэл сонирхлыг илрүүлсэн нь тодорхойгүй, боловсролын үйлчилгээний сэтгэл ханамж гэсэн шалгуур үзүүлэлтэд зарим цэцэрлэгүүд эцэг эх, асран хамгаалагчаас багшийн хүүхэд нэг бүрийн хөгжилд үзүүлсэн дэмжлэг, мэргэжлийн ёс зүйн асуудлаар санал асуулга авч үр дүнг нэгтгэж гаргаагүй байна.

Улирлын үр дүнгийн урамшууллыг хавтгайруулахгүйгээр журамд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу бодит гүйцэтгэлийг үнэлж олгох, бусдаасаа санаачлагатай үр дүнтэй ажиллаж байгаа багш ажилчдад ур чадварын нэмэгдлийг, мөн илүү цагийн хөлсийг тухай бүр тооцож олгох нь ажлын идэвхи санаачлалыг нэмэгдүүлэх хөшүүрэг болгох, хангалтгүй ажиллаж байгаа багш ажилтнууд өөртөө дүгнэлт хийх, өөрийгөө хөгжүүлэх нөхцлийг бий болгохоор байна.

Багшийн ажлын үнэлгээг журмын дагуу үнэлээгүй, төсөв мөнгө хүрэлцэхгүй гэсэн шалтгаанаар 80-аас дээш оноо буюу “Хангалттай сайн” үнэлгээ авсан багшид ур чадварын нэмэгдэл олгоогүй байна.

Хүчин чадлаас давсан хүүхэдтэй цэцэрлэгийн тогооч, үйлчлэгч нар багшийн нэгэн адил ачаалалтай ажиллаж, өглөө ажилд эрт ирэх, орой илүү цагаар ажилладаг боловч илүү цагийн хөлс олгогдоогүй байна.

Анги, бүлгүүдэд мэргэжлийн багшийн хүрэлцээ дутмаг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах багш болон биеийн тамирын багш байхгүй байна.

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 8.14-т “Сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тооноос хамаарч тусгай мэргэжлийн багш, эмч, сэргээн засалч, нийгмийн ажилтан ажиллуулж болно”, 8.16-д “Цэцэрлэгт бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлийн сургууль төгссөн хөгжмийн болон биеийн тамирын багш ажиллуулж болно” гэж тус тус заасан.

Аудитын хамрах хугацаанд аймгийн хэмжээнд СӨБ олгох байгууллагууд нь 591-624 ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулж ирсэн бөгөөд 147 бүлэгт арга зүйчээр 12, бүлгийн багш 147, дуу хөгжмийн багш 23, туслах багш 147 хүн ажилласан /Хүснэгт №9/ байна.

Хүснэгт №9 Цэцэрлэгийн ажиллагсдын тооны судалгаа

	Албан тушаал	2016-2017 он	2017-2018 он	2018-2019 он
1	Эрхлэгч	32	33	32
2	Арга зүйч	10	11	12
3	Бүлгийн багш	143	147	147
4	Дуу хөгжмийн багш	21	20	23
5	Туслах багш	141	147	147
6	Бусад ажиллагсад	244	263	263
	Нийт	591	621	624

2016-2018 онуудад 37-49 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдсан байна. Цэцэрлэгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах мэргэжлийн багш болон биеийн тамирын багш ажиллаагүй байна.

Б.2.2 Хүний нөөц мэргэжлийн зохих шаардлагыг хангаагүй байна.

2.2.1. Цэцэрлэгийн эрхлэгчдийн 94.3 хувийг холбогдох шалгуурт нийцүүлэн томилжээ.

БСШУСС-ын 2019 оны А/118 дугаар тушаалаар баталсан Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийн 2.3-т “Цэцэрлэгийн эрхлэгч нь цэцэрлэгт багш, аргазүйчээр ажилласан туршлагатай байх ба Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, албан тушаалын тодорхойлолт, үр дүнгийн гэрээг удирдлага болгоно” гэж заасан байна.

Мөн цэцэрлэгийн эрхлэгчийн ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолтод бакалавр, магистрийн зэрэгтэй байх, багш мэргэжилтэй, СӨБ-ын менежментээр мэргэшсэн, багшлах ба боловсролын удирдлагаар хослосон дадлага, туршлагатай байхаас гадна Цэцэрлэгийн хэв шинжийн онцлогийн талаар зохих мэдлэг, туршлагатай байх гэсэн шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна.

Төрийн өмчийн 31 цэцэрлэгийн эрхлэгчийн 64.5 хувь нь 1-5 жил, 22.6 хувь нь 5-10 жил, 12.9 хувь нь 10-аас дээш жил тухайн албан тушаалд томилогдон /хүснэгт №10/ ажиллажээ.

Хүснэгт 10. Цэцэрлэгийн эрхлэгчдийн ажлын туршлагын судалгаа

Өмнө нь ажиллаж байсан газар, албан тушаал	Ажилласан жил	Эрхлэгчийн тоо
Өөр байгууллагад багш, мэргэжилтэн	2-4	2
Цэцэрлэгт нярав	16	1
Цэцэрлэгт туслах багш, бүлгийн багш	1-5	6
	6-10	8
	11-дээш	7
Цэцэрлэгт дуу хөгжмийн багш	6-17	5
Цэцэрлэгт арга зүйч	3-6	4

Цэцэрлэгийн нийт 35 эрхлэгчдийн 94.3 хувь нь сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр бакалаврын боловсролтой, цэцэрлэгт туслах болон бүлгийн багш, мөн аргагүйч, хөгжмийн багшаар ажилласан туршлагатай байна. Харин Сайншанд сумын 10-р цэцэрлэг, Болор-Эрдэнэ цэцэрлэгийн эрхлэгч нар СӨБ-ын чиглэлээр бакалаврын боловсролгүй, багшлах эрхгүй байна.

2.2.2. СӨБ-ын чиглэлээрх мэргэжлийн багшийн хүрэлцээ дутагдалтай байгаагаас шалтгаалж нийт багш нарын 42.9 хувь нь холбогдох шаардлагыг хангахгүй байна.

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 12.1-т “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй багш ажиллана” гэж заасан байна. Мөн ажлын байрны тодорхойлолтод Бакалавраас доошгүй боловсролын зэрэгтэй, багш мэргэжилтэй, бага насны хүүхдийн хөгжил, сургуулийн өмнөх боловсролоор мэргэшсэн, багшлах дадлага хийсэн, багшлах эрхтэй байх гэсэн шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон.

2018-2019 оны хичээлийн жилд ажиллаж буй цэцэрлэгийн үндсэн багш 170 хүнээс мэргэжлээр нь авч үзвэл 77.1 хувь буюу мэргэжлийн 131 багш ажиллаж байгаа бөгөөд 39 нь мэргэжлийн бус хүн байна.

Багшлах эрх авсан байдлаар нь авч үзвэл 182 багш, арга зүйчдийн 57.1 хувь нь багш, арга зүйчид мэргэжлийн зэрэг олгох нийтлэг болон тусгай шалгуур үзүүлэлтийг хангасан, багшлах эрхтэй, 42.9 хувь нь буюу багшлах эрхгүй 78 багш байна. Жишээлбэл: Мэргэжлийн бус бүлгийн багш 31, дуу хөгжмийн багш 8 ажиллаж байна. /Эдгээрээс бүлгийн 20-иод багш мэргэжлийн сургуульд суралцаж байгаа бол мэргэжлийн бус 8 дуу хөгжмийн багш нар мэргэжлийн шаардлагыг хангахаар сургуульд суралцаж байгаа гэсэн тайлбар өгсөн/

Хувийн өмчийн 4 цэцэрлэгт 13 мэргэжлийн бус багш нар ажилладаг байна. Тухайлбал: Тухайлбал: Замын-Үүд сумын Ухаалаг багачууд цэцэрлэг 3 бүлэгтэй бөгөөд цэцэрлэгийн эрхлэгч сургуулийн өмнөх насны хүүхдийн багш

мэргэжилтэй, бүлгийн 3 багшийн нэг нь биеийн тамирын багш, дасгалжуулагч мэргэжилтэй, нөгөө нь баклавр зэрэгтэй монгол хэл, уран зохиолын багш, мөн Төгс боловсрол сургалтын төвийн сургалтад хамрагдсан туслах багшийн сертификаттай багш ажиллаж байна.

Цэцэрлэгт бага насны хүүхдийг хөгжүүлж, хүмүүжүүлэх чиглэлээр 3 кредит цагаас доошгүй хугацааны сургалтад хамрагдсан туслах багш ажиллах ёстой. Цэцэрлэгийн туслах багш нар Чухал амжилт, Акура, Жавхлант энх эрдэнэ, Гэрэлтэх мэргэжил зэрэг сургалтын төвд суралцаж чадамжийн гэрчилгээ, сертификаттай байв. Иймд СӨБ-ын байгууллагад ажиллаж буй туслах багш нар дээрх шалгуурыг хангасан байна.

2.2.3. Багш нар мэргэших сургалт болон эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байна.

БСШУС-ын 2013 оны А/327 дугаар тушаалаар баталсан Сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлогын 4.4-т хүний нөөцийг бэлтгэх, чадваржуулах чиглэлийг тусгасан байна.

БСШУС-ын 2014 оны А/52 дугаар тушаалаар баталсан “СӨБ-ын байгууллагын багшид багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах, арга зүйчид мэргэжлийн зэрэг олгох хасахад баримтлах шалгуур үзүүлэлт”-ийн 2.1-д багшлах эрх олгоход дараах нийтлэг шалгуур үзүүлэлтийг баримтлахаар заасан байна.

Багш нь СӨБ-ын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1- заасан боловсролын зэрэгтэй байхаас гадна заах арга зүйн хөрвөх сургалтад хамрагдсан байх

- Багшийн ёс зүйг чанд сахин, холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажилладаг байх
- Хүүхэд нэг бүрийн онцлогийг нээх, хөгжлийг дэмжих арга зүй, технологийг эзэмшсэн байх
- Судалгаа хийх, гадаад хэл, мэдээлэл технологийн зохих түвшний мэдлэг, чадвартай байх

Тайлант жилүүдэд Багшийн мэргэжил дээшлүүлэх институтээс зохион байгуулдаг багш нарын мэргэжил дээшлүүлэх анхны жилийн үндсэн сургалтад нийт 40 багш, 5 жилийн сургалтад 49 багш, 10 жилийн сургалтад 44 багш хамрагдсан /хүснэгт №11/ байна.

Хүснэгт 11. Сургалтанд хамрагдсан багш нарын судалгаа

		2016 он	2017 он	2018 он	2019 он	Дүн
1	Анхны жилийн сургалт	3	10	12	15	40
2	5 жилийн сургалт	4	11	13	21	49
3	10 жилийн сургалт	2	26	7	9	44
	Дүн	9	47	32	45	133

“СӨБ-ын байгууллагын багшид багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах, арга зүйчид мэргэжлийн зэрэг олгох хасахад баримтлах шалгуур үзүүлэлт”-ийн дагуу мэргэшүүлэх сургалтад багш нар хамрагдсанаар багш, аргазүйчийн ур чадвар,

арга зүй үүрэг хариуцлага дээшлэх, хүүхэдтай ажиллах арга барил нь сайжрах, багшлах эрхээ авах, сунгах зэрэг үр дүнтэй ажил болсон байна.

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/45 дугаар тушаалаар баталсан журамд заасны дагуу хичээлийн жил эхлэхээс өмнө 30 хоногийн дотор эмч, багш, ажилчид эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт, шинжилгээнд хамрагдсан байх үүрэгтэй болохыг заасан.

Цэцэрлэгийн эрхлэгч, аргазүйч, багш, тогооч, эмч нар 100 хувь, манаач нарын зарим нь эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж сүрьеэ, арьсны халдварт өвчин, хамар залгиурын арчдас, цагаан хорхойн шинжилгээнд хамрагдсан байна.

Б.3 СӨБ-ын үйл ажиллагаанд олгож байгаа төсвийг зардал болон цэцэрлэгүүдийн хооронд гүйлгэн зарцуулж анхны батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

3.1. Төсвийг зардлын нормативаар хуваарилж буй нь бодитой бус байгаагаас төлөвлөлт, хуваарилалт оновчгүй байна.

3.1.1. Хувийн цэцэрлэгт олгосон төсвийн хуваарилалт оновчгүй байна.

Хувийн цэцэрлэгт хувьсах зардлын нормативаар тооцож төсөв хуваарилан, санхүүжүүлж ирсэн бөгөөд анхны төсвийн хуваарилалтаар бүтэн жилийн үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна. Бусад хувьсах зардлын хуваарилагдсан төсөв нь тухайн цэцэрлэгт ариутгал хийх, хичээлийн хэрэглэгдэхүүн, нормын хувцас, зөөлөн эдлэл авахад хүрэлцэхгүй байна. Төрийн цэцэрлэгүүдэд тодотголоор төсвийн зохицуулалт хийдэг бол хувийн цэцэрлэгүүдэд тодотгол хийгдээгүй байна. Иймд хувийн цэцэрлэгийн төсвийн хуваарилалт оновчгүй байна.

3.1.2. Улсын цэцэрлэгийн хоолны зардлыг төсвөөс бүрэн олгосон байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн 31 цэцэрлэгт 2016-2019 онуудад эцэг эхээс хүүхдийн хоолны мөнгө аваагүй, хоолны мөнгийг 100 хувь улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

3.1.3 Нэг хүүхдэд ногдох нормативт зардлын хэмжээ бодитой бус байгаагаас төсвийн төлөвлөлт оновчтой хийгдэхгүй байна.

БСУГ, аймгийн Засаг даргаас төсвийн төсөл боловруулахдаа хүснэгт №12 дэх тооцооллыг хийж хүргүүлсэн байна.

Хүснэгт 12. Төсвийн төслийн судалгаа

		2016 оны төсвийн төсөл		2017 оны төсвийн төсөл		2018 оны төсвийн төсөл	
		Хүүхдийн тоо	Дүн /сая.төг/	Хүүхдийн тоо	Дүн /сая.төг/	Хүүхдийн тоо	Дүн /сая.төг/
1	Төрийн өмчийн цэцэрлэгт өдрөөр хамруулах үйлчилгээ	4809	8923.6	5219	9,482.7	5224	10,156.5
2	Хувилбарт сургалтад хамруулах үйлчилгээ	817	298.3	406	91.3	467	92.4
3	Төрийн бус өмчийн цэцэрлэг	430	657.7	0	427.5		
	Төсвийн төслийн нийт дүн	6056	9879.6	5625	10,001.5	5691	10,248.9

СӨБ-ын байгууллагуудын батлагдсан төсөвт 2016 онд төсвийн дүнг 62.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2017 онд 3.9 сая төгрөгөөр хасаж, 175.2 сая төгрөгөөр

нэмж 2 удаа өөрчлөлт хийсэн, 2018 оны төсвийн дүнг 316.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж тус тус өөрчилж төсөв баталсан байна. Энэхүү өөрчлөлтийг аудитын тайлангийн хавсралт №1-д харуулав.

Төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг хэрхэн гүйцэтгэсэн байдалд 2017 оныг сонгон судаллаа. БСУГ болон аймгийн Засаг дарга 2017 онд стасистик мэдээний бодит дүнд үндэслэн 5625 хүүхдийг СӨБ-д хамруулж 10.0 тэрбум төгрөгийн үйлчилгээ үзүүлэхээр төсвийн төсөл боловсруулж сангийн яаманд хүргүүлсэн байна. Сангийн яамнаас төсвийн төслийн хүүхдийн тоог 539-өөр хасаж 5086 хүүхэд болгож, төсвийг 2977.7 сая төгрөгөөр хасаж 7023.8 сая төгрөгөөр хянасан байна. Аймгийн ИТХ-ын тогтоолоор сангийн яамны хянасан дүнгээр СӨБ-ын байгууллагын 2017 оны төсвийг баталсан ба БСШУСС-ын сайдаас 2017 оны 01 дүгээр сард СӨБ-ын төсвийн санхүүжилтийн хуваарь ирүүлсэн байна.

МУ-ын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбоотойгоор 2017 оны 05 дугаар сард санхүүжилтийн хуваарийг тодотгож 7019.8 сая төгрөгөөр ирүүлснийг аймгийн ИТХ-ын 04/02 дугаар тогтоолоор баталсан байна. Энэ нь өмнөх төсвөөс 4.0 сая төгрөгөөр хасагдсан байна.

Байгууллагуудын өмнөх төсвийн хуваарьт өөрчлөлт оруулахдаа 5-н цэцэрлэгийн төсвөөс 55.3 сая төгрөг хасч, 4-н цэцэрлэгийн төсөв дээр 51.3 сая төгрөг нэмсэн байх ба төрийн өмчийн ихэнх цэцэрлэгийн нормативт хувьсах зардал болон тогтмол зардлуудыг зардал хооронд шилжүүлж өөрчлөлт хийсэн байна.

БСШУСС-аас 2017 оны тодотгосон төсвийг хэрэгжүүлэх чиглэл, төсөвт зохицуулалт хийх тухай албан бичгийг үндэслэн СӨБ-ын төсвийг 175.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх тооцооллыг БСУГ-аас оруулжээ. Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 06/01 дүгээр тогтоолоор аймгийн 2017 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд энэхүү өөрчлөлтөөр хүүхдийн цэцэрлэгийн төсвийг 7195.1 сая төгрөг буюу 175.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Энэ тодотголоор 8 цэцэрлэгийн төсвийг 248.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 7 цэцэрлэгийн төсвийг 73.7 сая төгрөгөөр бууруулжээ. Өмнө хийсэн төсвийн өөрчлөлтийн нэгэн адил бүх цэцэрлэгүүдийн зардал хооронд гүйлгэн шилжүүлэх, зардлын дүнг нэмэгдүүлж, бууруулах зэрэг өөрчлөлт хийсэн байна. Тухайлбал: Төсвийн тодотголоор Даланжаргалан, Хатанбулаг сумын цэцэрлэгийн төсөвт орсон өөрчлөлтийг хүснэгт 13-т харуулав.

Хүснэгт 13. Төсөвт орсон өөрчлөлтийн судалгаа

	Зардлын төрөл	Даланжаргалан цэцэрлэг		Хатанбулаг цэцэрлэг	
		Эхний өөрчлөлт	Сүүлийн өөрчлөлт	Эхний өөрчлөлт	Сүүлийн өөрчлөлт
1	Цалингийн зардал	-14400.0		14000.0	5300.0
2	НДШ			1540.0	1320.0
3	Гэрэл цахилгаан		-1200.0		-1000.0
4	Түлш халаалт		-5000.0	-1540.0	
5	Цэвэр бохир ус		-1077.0	-1500.0	-2000.0
6	Хангамж бараа материал	4600.0	6000.0	2000.0	1000.0
7	Хоол хүнсний зардал	-6800.0	-6000.0	-16000.0	-8000.0
8	Нормын хувцас, зөөлөн эдлэл				5874.1
9	Томилолтын зардал	200.0			
10	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ		250.0		800.0
11	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		5100.0		6600.0
	Дүн	-16400.0	-1927.0	-1500.0	9894.1

Даланжаргалан сумын цэцэрлэгийн цалин, тогтмол зардал, хоол хүнсний зардлыг 34.5 сая төгрөгөөр бууруулж, хангамж бараа материал, томилолт, БГАҮ, НУТУ-ын зардлыг 16.2 нэмэгдүүлж төсвийг нийт 18.3 сая төгрөгөөр бууруулсан байна.

Хатанбулаг сумын цэцэрлэгийн цалин, шимтгэл, хангамж бараа материал, нормын хувцас, зөөлөн эдлэл, БГАҮ, НУТУ-ын зардлыг 38.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж тогтмол зардал, хоол хүнсний зардлаас 30.0 сая төгрөг бууруулж төсвийг нийт 8.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Судалгаагаар хоол хүнсний зардлыг 2018 онд 43.5 сая төгрөгөөр, 2017 онд 164.0 сая төгрөгөөр, 2018 онд 91.1 сая төгрөгөөр тус тус хасаж /аудитын хавсралт 1-д хийсэн/ бусад зардал, цэцэрлэгүүдэд хуваарилсан байна.

Төсвийн тухай хуулийн 45.2.-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.1. “нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ” гэсэн заалтыг зөрчиж зарцуулагдаагүй **298.6 сая** төгрөгийн хүүхдийн хоолны зардлын төсвийн үлдэгдлийг дансанд төвлөрүүлээгүй байна. Үүнд зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага бичлээ.

Эдгээр нөхцөл байдал нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг хангалтгүй хэрэгжүүлж төсвийг бодитой төлөвлөөгүй, үр ашигтай хуваарилаагүй байна.

Төсвийн тухай хуулиар аймгийн Засаг дарга 3 тохиолдолд төсвийн тодотголыг боловсруулж ИТХ-д өргөн мэдүүлнэ. Түүний нэг заалт болох 34.2.1-д “Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас зайлшгүй шаардлага бий болсон” тохиолдолд тодотгол хийх ёстой.

Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 1650 төгрөг байхаар тогтоосон.

Төсвийн 2017 оны төсөлд цэцэрлэгийн үйлчилгээний хүүхэд өдрийг төрийн өмчийн цэцэрлэгт 969760 хүүхэд өдрөөр, хувилбарт сургалтын 11189 хүүхэд өдрөөр төлөвлөсөн байна. Үүнийг нэг хүүхдэд ногдох хоолны зардлын 1650 төгрөгөөр тооцоход танхимын сургалтаарх хүүхдийн хоолны зардал 1600.1 сая төгрөг, хувилбарт сургалтын хоолны зардал 18.5 сая төгрөг нийт 1618.6 сая төгрөг байна.

Сангийн яамнаас цэцэрлэгт хамрагдах нийт хүүхдийн тоог 70 гаруй хувиар тооцож хянасан байв. СӨБ-ын байгууллагын 2017 оны төсөвт хоолны зардлыг Сангийн яамнаас 1186.3 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг тооцох бүрэлдэхүүн, нормативын хэмжээ, санхүүжүүлэх аргачлалыг

баталсан ба нормативыг тооцох бүрэлдэхүүнд хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилтны албан тушаалын цалин болон нэмэгдэл цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, бараа үйлчилгээний бусад хувьсах зардал байна. СӨБ-ын байгууллагууд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг баримтлалгүй цалингийн санг орон тоогоор тооцсон, бусад хувьсах зардлыг тооцохдоо ч нормативыг баримтлаагүй байна. Тухайлбал: Нэг хүүхдэд ногдох нормативт цалин дээр стандарт бүлэг дүүргэлтээс давсан цалин /цэцэрлэгийн энгийн өдрийн хүүхдийн тоо, нормативт хүүхдийн тооны зөрүүгээр тооцсон/, мэргэжлийн зэргийн цалинг нэмж нийт цалингийн төсвийг тооцсон байв. Бараа үйлчилгээний бусад хувьсах зардлыг цалингийн зардлын нэгэн адил төлөвлөгөөнөөс давсан хүүхдийн тооны бараа үйлчилгээний бусад хувьсах зардал нормативт бараа үйлчилгээний хувьсах зардлын нийлбэрээр тооцсон байна.

Засгийн газрын тогтоол, шийдвэрүүд удаа дараалан шинэчлэгдэж, дүрэм журам жил бүр өөрчлөгдөж байхад эдгээр нь хувьсах зардалтай уялдаагүй тул төсвийн төлөвлөлтөд цалингийн асуудал тодорхойгүй, СӨБ-ын орчны болон эрүүл ахуйн стандартын дагуу материал, эд зүйлс, сургалтын хэрэглэгдэхүүнийг худалдан авах зардлын төсөвт уялдаатай тусгахгүй байгаагаас тус зардлууд хүрэлцээгүй батлагддаг байна.

3.1.4.Цэцэрлэгүүдэд шаардлагатай хичээлийн хэрэглэгдэхүүн, ном гарын авлага, тоглоом, ариутгалын материал авахаар төлөвлөдөг боловч батлагдсан зардлын төсөв хүрэлцэхгүй байна.

Бараа үйлчилгээний бусад хувьсах зардлыг /10 нэр төрлөөр/ сумын цэцэрлэгт 27.9 мянган төгрөгөөр, аймгийн төвийн цэцэрлэгт 25.1 мянган төгрөгөөр тооцох нормативт хэмжээг тогтоосон байна.

Аймгийн төвийн цэцэрлэгийн хамгийн олон хүүхэдтэй 9-р цэцэрлэг, хамгийн бага хүүхэдтэй Сайхандулаан сумын цэцэрлэгийг сонгон 2018 оны бараа үйлчилгээний бусад хувьсах зардлын төсвийн нормативаар тооцсон зардал, батлагдсан төсвийг харьцуулан Хүснэгт №14-т харуулав.

Хүснэгт №14. Бусад хувьсах зардлын нормативт төсөв, батлагдсан төсвийн харьцуулалтын судалгаа

		Сайншанд сумын 9-р цэцэрлэг			Сайхандулаан сумын цэцэрлэг		
		Хүүхдийн тоо	Нормативаар тооцсон зардал	Баталсан төсөв /мян.төг/	Хүүхдийн тоо	Нормативаар тооцсон зардал	Баталсан төсөв /мян.төг/
1	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	262	6576.2		53	1478.7	
2	Бичиг хэрэг			100.0			60.0
3	Ном хэвлэл			140.0			130.0
4	Шуудан холбоо			86.0			270.0
5	Томиллолт			90.0			253.0
6	БҮТЭЗ			1488.7			3275.0
7	Нормын хувцас, зөөлөн эдлэл			376.8			300.0
8	Эм бэлдмэл			98.8			17.0
9	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчийн устгал, ариутгал			150.0			0
10	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж			798.6			843.4
	Дүн	262	6576.2	3328.9	53	1478.7	5148.4

Сайншанд сумын 9-р цэцэрлэгийн нормативаар тооцсон бараа үйлчилгээний бусад хувьсах зардал 6576.2 мянган төгрөг байхаар байхад 3328.9 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь нормативаар тооцсон дүнгээс 3247.3 мянган төгрөгөөр төсвийг дутуу баталсан байна.

Сайхандулаан суманд нормативаар тооцсон бараа үйлчилгээний бусад хувьсах зардал 1478.7 мянган төгрөг байхаар байхад 5148.4 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь нормативаар тооцсон дүнгээс төсвийг 3669.7 мянган төгрөгөөр илүү баталжээ.

Дээрх байдлаас харахад нэг суралцагчид ногдох нормативын хэмжээ бодитой бус байгааг илтгэн харуулж байна. Хүүхдийн тоо их байх тусам тухайн цэцэрлэгт зардлын төсөв бодит гүйцэтгэлээс илүү тооцогдох, хүүхдийн тоо бага байх тусам холбогдох зардалд төсөв хүрэлцэхгүй байгааг харуулж байна. Үүнээс шалтгаалж төсвийн хуваарилалтыг оновчгүй хийх, стандартын дагуу шаардлагатай нормын хувцас, зөөлөн эдлэл, ном, гарын авлага, тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнийг авах зардлын төсөв хүрэлцэхгүй байна.

Төсвийн хуваарилалт оновчгүй хийгдэж байгаагаас шалтгаалан стандартын дагуу шаардлагатай нормын хувцас, зөөлөн эдлэл, ном, гарын авлага, тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнийг худалдан авах зардлын төсөв хүрэлцэхгүй байна.

3.2. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

3.2.1. Хүүхэд өдрөөр хянасан хүүхдийн хоолны зардлын төсвийн хэмнэлтийг өөр зардалд хуваарилсан, хувилбарт сургалтын үр дүн хангалтгүй байна.

БСШУС-ын 2012 оны А/131 дүгээр тушаалаар баталсан “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалт зохион байгуулах журам”-ын хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал: БСУГ-ын мэргэжлийн дүгнэлт гараагүй, хувилбарт сургалтын үйлчилгээ үзүүлэх цэцэрлэгийг үнэлээгүй, хувилбарт сургалтад хамрагдах хүүхдүүдийн эцэг эхтэй гэрээ байгуулаагүй, журамд заасан сургалтын орчин бүрэн хангагдаагүй байна.

Тус журмаар БСУГ хувилбарт сургалтад хамрагдсан хүүхдийн эзэмшсэн мэдлэг, чадвар дадлыг үнэлж санхүүжилтийг тооцохоор заасан байна. “Хувилбарт сургалтын үйлчилгээний тээвэр, түлш, томилолтын зардал болон шаардлагатай бусад зардлыг тухайн жилийн цэцэрлэгийн төсөвт тусгаж зарцуулна” гэж заасан хэдий ч хувилбарт сургалтын шатахуун, томилолтын зардлыг төсвийн төсөлд тусгайлан оруулж тооцоогүй байна.

Хүснэгт 15. Хувилбарт сургалтын төлөвлөгөө

	2016 он		2017 он		2018 он	
	Хамрагдах хүүхэд	Зардлын дүн	Хамрагдах хүүхэд	Зардлын дүн	Хамрагдах хүүхэд	Зардлын дүн
Хувилбарт сургалтад хамруулах үйлчилгээний төлөвлөгөө	817	298.3	406	91.3	467	92.4

Хувилбарт сургалтын хоолны зардлын тайланг гаргасан байх боловч цалингийн бүртгэлд хувилбарт сургалт явуулсан хугацааг бүртгээгүй, хувилбарт сургалттай холбоотой цалингийн зардалд хэдэн төгрөг зарцуулсан нь тодорхой бус байна. Иймд хувилбарт сургалтын зардлын төсвийн хэтрэлт хэмнэлтийг тооцон гаргах /хүснэгт 15/ боломжгүй байна.

Аймаг, сумын төрийн сангаас цэцэрлэгүүдийн батлагдсан төсөв, хуваарийг үндэслэн санхүүжилт, зарлагын гүйлгээг тухай бүр хийдэг бөгөөд хүүхэд өдөрт хяналт тавиагүй байв.

Цэцэрлэгийн эд хариуцагчийн тайлангаар гарсан хүүхдийн хоолны зардлын бодит гүйцэтгэлийг хоолны зардлын баталсан төсөвтэй /хүснэгт №16/ харьцуулахад:

Хүснэгт №16 Хоолны зардлын судлгаа

	Цэцэрлэгийн нэр	Нормативаар			Бодит гарсан зардал /сая төгрөг/	Нэг хүүхдэд ногдох зардал /төгрөг/	Зөрүү дүн /сая төгрөг/	Төсвийн дүн /сая төгрөг/ 2016-2018	Төсвийн хэмнэлт, хэтрэлт	Тайлбар
		2016-2018 оны хүүхэд өдөр	Зардлын хэмжээ /төгрөг/	Мөнгөн дүн /сая төгрөг/						
	А	1	2	3	4	5/4:1/	6/3-4/	7	8/7-4/	
1	Сайншанд 1	48633	1650	80.2	79.7	1640	0.5	77.4	-2.3	
2	Сайншанд 2	84512	1650	139.4	139.9	1655		140.5	0.6	
3	Сайншанд 9	115000	1650	189.8	188.4	1638	1.4	187.6	-0.8	
4	Сайншанд 11	80792	1650	133.3	129.6	1603	3.7	132.7	3.1	
5	Сайншанд 12	67921	1650	112.1	111.1	1636		132.6	21.5	/2017 оны 1-5 сарын бараа материалын баримт байхгүй/
6	Замын-Үүд 3	109323	1650	180.4	176.0	1610	4.4	185.1	9.1	
7	Замын-Үүд 5	16449	1650	27.1	26.8	1631	0.3	29.8	3.0	
8	Сайхандулаан	23488	1650	38.7	38.0	1617	0.7	35.7	-2.3	

Аудитад хамрагдсан цэцэрлэгүүд сүүлийн 3 жилд нэг хүүхдэд ногдох зардлын хэмжээг хэтрүүлээгүй бөгөөд зардлын төсвийг 3 цэцэрлэг 0.8-2.3 сая төгрөгөөр хэтрүүлж, 4 цэцэрлэг 0.6-9.1 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Хүүхдийн хоолны зардлын нормативыг баримтлан ажилласнаас хүүхдийн хүнсний бүтээгдэхүүнээс авах илчлэгийн хэмжээ хангагдахгүй байх эрсдэл үүсч байгаа тул цаашид хоолны зардлын хэмжээг нэмэгдүүлж, шинэчлэн батлах шаардлагатай байна.

Цэцэрлэгүүд нэг хүүхдэд ногдох хоолны зардлын хэмжээг хэтрүүлэхгүйгээр байнгын хяналт тавьж ажилласан байх ба харин өвчтэй, чөлөөтэй, бусад шалтгаанаар ирээгүй хүүхдийн хоолны зардлаас үүссэн хэмнэлтийг байгууллагын бусад хүрэлцэхгүй зардалд шилжүүлэн хуваарилуулж зарцуулсан байна.

3.2.2. Цэцэрлэгүүд тухайн сумынхаа зах зээл дэх үнэ ханшаар хүнсний материалыг худалдан авсан байна.

Сайншанд сумын цэцэрлэгүүдийн хоол, хүнсний материалыг Сайншанд сумын ЗДТГ-аас нэгдсэн журмаар МУ-ын ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу “Хүнсний бүтээгдэхүүн”, “Сүү, сүүн бүтээгдэхүүн, жимс, жимсгэнэ”, “Хүнсний ногоо”, “Цэвэр ус”, “Мах” гэсэн багцаар худалдан авах ажиллагааны тендерийг зарлаж, бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулсан байна. Хүнсний бүтээгдэхүүний багцуудад шалгарсан компани Сайншанд сумын дийлэнх цэцэрлэгүүдэд тухайн багцын бүтээгдэхүүнийг хичээлийн жилд /2018 оны 09 сарын 01-ээс 2018 оны 06 сарын

01/, нийлүүлэхээр гэрээ байгуулан гүйцэтгэсэн байна. Тухайлбал: Суман зурхай ХХК үхэр, хонины мах нийлүүлэх, Цагаан сүүний буян ХХК сүү, сүүн бүтээгдэхүүн, жимс, жимсгэнэ, Таван хааны өргөө ХХК хүнсний ногоо нийлүүлж иржээ.

Замын-Үүд сумын 3 болон 5 дугаар цэцэрлэгүүд бэлтгэн нийлүүлэгчийг сонгохдоо тодорхой шалгуур үзүүлэлтийг баримтлаагүй, үнийн харьцуулалт хийхгүйгээр тус суманд байрлах үйл ажиллагаа нь тогтмолжсон дэлгүүр, иргэдтэй хоол, хүнсний материал худалдан авах гэрээ байгуулан ажилласан байна. Тухайлбал: Жинчин УБТЗ-ын дэлгүүр талх нарийн боов, Аса баянсайхан ХХК сүү, сүүн бүтээгдэхүүн, Дэвжих мөнхийн-Од ХХК өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүн нийлүүлсэн байна.

Сайхандулаан сумын цэцэрлэг нь бэлтгэн нийлүүлэгчийг сонгохдоо тодорхой шалгуур үзүүлэлтийг баримтлаагүй, үнийн харьцуулалт хийгээгүй, тус суманд хүнсний бүтээгдэхүүн борлуулдаг байгууллага, иргэн цөөн байдгаас шалтгаалан аймгийн төвөөс хоол хүнсний материалаа бэлтгэдэг ба тээврийн зардал нэмэгдэх, цаг хугацаа алдах, улмаар хүүхдийн хоолны нормативт хэмжээнд нөлөөлөх бэрхшээл үүсдэг байна.

Худалдан авсан хүнсний бүтээгдэхүүний үнийг тухайн үеийн аймгийн статистик үзүүлэлтийн үнэ ханштай харьцуулахад Замын-Үүд, Сайхандулаан суманд нийлүүлсэн зарим хүнсний бүтээгдэхүүний үнэ зах зээлийн үнээс 34-2400 төгрөгөөр дээгүүр, харин Сайншанд сумын цэцэрлэгүүдэд нийлүүлсэн бүтээгдэхүүний үнэ зах зээлийн үнээс 50-2500 төгрөгөөр доогуур байна.

- Сайншанд сумын 2-р цэцэрлэгт төмс 50 төгрөг, сонгино 120 төгрөг, ургамлын тос 233 төгрөг, цагаан будаа 60 төгрөг, тараг 200 төгрөг, үхрийн мах 2500 төгрөг, хонины мах 570 төгрөгөөр тус тус зах зээлийн үнээс доогуур байна.
- Замын-Үүд сумын 3-р цэцэрлэгт зах зээлийн үнээс төмс 77 төгрөгөөр, талх 260 төгрөгөөр тус тус дээгүүр, сонгино 240 төгрөгөөр, ургамлын тос 34 төгрөг, цагаан будаа 320 төгрөг, тараг 60 төгрөг, үхрийн мах 2400 төгрөг, гурилан боов 500 төгрөгөөр тус тус зах зээлийн үнээс доогуур байна.
- Сайхандулаан сумын цэцэрлэгт төмс 295 төгрөгөөр, сонгино 300 төгрөг, цагаан будаа 530 төгрөг, үхрийн мах 2400 төгрөг, гурилан боов 1330 төгрөг, талх 600 төгрөгөөр тус тус зах зээлийн үнээс дээгүүр, хонины мах 570 төгрөгөөр доогуур үнээр бэлтгэсэн байна.

Сумдын цэцэрлэгүүд хоол хүнсний материалыг худалдан авах гэрээ хийхдээ үнийн судалгаа хийж баримтжуулаагүй, ямар хугацаанд, ямар үнээр нийлүүлэхийг гэрээнд тусгаагүй зөрчил түгээмэл байна.

3.2.3. Төсвийн зарцуулалт, бүртгэл, тайлагналд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Төрийн өмчийн цэцэрлэгүүдийн 2016-2018 оны санхүүгийн тайланд хийсэн СТА-ын 3 жилийн дүнгээс харахад 2016 онд Алтанширээ, Мандах, Улаанбадрах сумын цэцэрлэг, Сайншанд сумын 6-р цэцэрлэгт итгэл үзүүлж, давхардсан тоогоор 22 цэцэрлэг түүвэрт хамрагдсан байна. Хязгаарлалттай дүгнэлт авсан 8 цэцэрлэг, /1 цэцэрлэг 2 жил дараалан хязгаарлалттай дүгнэлт авсан/ байна.

Аудитад хамрагдах хугацаанд аудитаар нийт 3446.0 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс НББ-ийн тайлагналтай холбоотой 3372.3 сая төгрөгийн, арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой 18.5 сая төгрөгийн, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 38.7 сая төгрөгийн, дотоод хяналт, хариуцлагатай холбоотой 4.1 сая төгрөгийн, зориулалт бус зарцуулалттай холбоотой 12.4 сая төгрөгийн зөрчил байна.

Санхүүгийн тайлангийн аудитын дүнгээс харахад 2016-2018 онд төсөв, санхүүгийн хяналт, хариуцлага сул байсныг харуулж байна.

Аймагт шинээр 100-150 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг баригдаж, үйл ажиллагаа явуулж эхлэхэд улсын төсөвт хэдэн төгрөгийн урсгал зардал шинээр нэмэгдэж байгааг харьцуулахад: Сайншанд сумын 13 дугаар цэцэрлэг нь 150 хүүхдийн хүчин чадалтай бөгөөд 2018 онд ашиглалтад орсон байна. Тус цэцэрлэгийн нийт урсгал зардал 286.1 сая төгрөг байна. Замын-үүд сумын 5-р цэцэрлэг 100 хүүхдийн хүчин чадалтай ба нийт урсгал зардлын хэмжээ 194.8 сая төгрөг байна.

Аудитад хамрагдсан жилүүдэд СӨБ-ын байгууллагуудын тухайн жилийн төсөвт 1-2 удаа салбарын төсвийн нийт дүнг нэмэгдүүлэх, хэмнэгдсэн зардлыг бусад зардлуудад хуваарилан нийт дүнд зохицуулалт хийн зарцуулж байгаа нь төсвийн төлөвлөлт оновчгүй байгаа, мөн төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй зарцуулахгүй байгааг харуулж байна.

3.2.4. СӨБ-ын байгууллагын шинээр баригдсан барилгууд орчны стандартыг бүрэн хангаагүй байна.

Цэцэрлэгийн барилгын зургийг нь орчны стандартын шаардлагын дагуу хийгээгүйгээс шалтгаалж барилга ашиглалтад орж үйл ажиллагаа явуулах үед бэрхшээл гардаг байна. Тухайлбал шинээр баригдсан зарим цэцэрлэгт шаардлага хангахгүй шатны бариул, цонх хийх, суултуурын өндрийн хэмжээ, тосгуур хоорондын зай алдагдах, гадна талбайн тохижилт, гэрэлтүүлэг, камер, дохиоллын систем суулгаагүй, гал тогоонд стандартын тосгуур байхгүй гэх мэт асуудал үүссэн байна.

Б.4. Хууль журмын заалтыг мөрдөж ажиллаагүйгээс СӨБ олгох үйлчилгээнд тавьж буй хяналт хангалтгүй байна.

Б.4.1. СӨБ олгох байгууллагын түвшинд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Хууль журмын заалтыг мөрдөж ажиллаагүйгээс цэцэрлэгийн удирдлагын хяналт орхигдсон байна.

СӨБ-ын тухай хуулийн 10.2-т Цэцэрлэгийн өөрийн удирдлага нь цэцэрлэгийн зөвлөл байх бөгөөд түүнийг Боловсролын тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу байгуулна.

БСШУС-ын 2002 оны 230 тушаалаар ЕБС, цэцэрлэгийн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм батлагдсан байна. Цэцэрлэгийн зөвлөл нь цэцэрлэгийн зохион байгуулалт,

дүрэм, журам, санхүү, хөрөнгө оруулалт, хүүхдийн хөгжил, хамгааллын асуудлаар санал өгөх, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй. Аудитад хамрагдсан ихэнх цэцэрлэгүүд хууль⁵ дүрмийн дагуу цэцэрлэгийн зөвлөл байгуулаагүй, зөвлөл байгуулсан нь үйл ажиллагаа тогтмолжоогүй, хуульд заасан чиг үүргийг⁶ төлөвлөж, хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

Сайншанд 2-р цэцэрлэг: Цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны А/10 тоот тушаалаар цэцэрлэгийн Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилсон. Цэцэрлэгийн зөвлөлийн ажлын төлөвлөгөө, тайлан үйл ажиллагаатай холбоотой нотлох баримт байхгүй байна.

Сайхандулаан сумын цэцэрлэг: Сайхандулаан сумын цэцэрлэгийн эрхлэгчийн 2017 оны А/11 тоот тушаалаар Цэцэрлэгийн зөвлөлийн бүрэлдэхүүн томилогдсон, 2019 оны Зөвлөлийн ажлын төлөвлөгөө боловсруулсан боловч хуульд заасан чиг үүргийг төлөвлөөгүй.

Сайншанд 12-р цэцэрлэг: Цэцэрлэгийн эрхлэгчийн 2017 оны А/19 дүгээр тушаалаар Цэцэрлэгийн зөвлөлийн бүрэлдэхүүн томилсон байна. 2018-2019 онд баталсан цэцэрлэгийн зөвлөлийн дүрэм, төлөвлөгөөнд хуульд заасан чиг үүрэг тусгагдаагүй байна.

Сайншанд 9-р цэцэрлэг: Цэцэрлэгийн эрхлэгчийн 2017 оны А/08 дугаар тушаалаар Цэцэрлэгийн зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм баталсан. Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, зохион байгуулсан ажлын тайлантай холбоотой нотлох баримт байхгүй байна.

Замын-Үүд сумын 3-р цэцэрлэг: Хуулийн дагуу багш, ажилтан, эцэг эхийн төлөөлөл бүхий цэцэрлэгийн зөвлөлийг 2018 оны А/05 тоот тушаалаар байгуулж, 2018-2019 онд хийх ажлын төлөвлөгөө гаргасан боловч зохион байгуулсан ажил байхгүй байна.

СӨБ-ын байгууллагууд Цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагааг хуулийн дагуу төлөвлөн зохион байгуулаагүйгээс цэцэрлэгийн үйл ажиллагааны тайлан хэлэлцэх, үнэлэх, эрхлэгчийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналт орхигдсон байна.

⁵Боловсролын тухай хуулийн 35.1.Сургууль, цэцэрлэгийн зөвлөл нь багш, ажилтан, сурагч, эцэг, эх, бусад байгууллагын төлөөлөлтэй байна. 9-11 гишүүнтэй сургууль, цэцэрлэгийн зөвлөлийг 3 жилийн хугацаагаар сонгоно. 35.2.Сургууль, цэцэрлэгийн зөвлөлд орох багш, ажилтан, сурагч, эцэг, эхийн төлөөллийг тэдгээрийн хамт олны хурлаас тус тус сонгоно. 35.3.Сургууль, цэцэрлэгийн зөвлөлд орох бусад байгууллагын төлөөллийг үүсгэн байгуулагчийн саналыг үндэслэн сургууль, цэцэрлэгийн нийт ажилтны хурлаас сонгоно.

⁶Боловсролын тухай хуулийн 35.4.Сургууль, цэцэрлэгийн зөвлөл нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: 35.4.1.сургууль, цэцэрлэгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм, журам батлах, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх; 35.4.2.сургууль, цэцэрлэгийн дэг журам, дотоод зохион байгуулалтын хэлбэрийг тодорхойлох; 35.4.3.сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааны тайлан хэлэлцэх, үнэлэлт, дүгнэлт өгөх; 35.4.4.сургалтын чанар, хүүхэд төлөвшүүлэх, хамгаалах, хөгжүүлэх ажлын үр дүн, түвшинг сайжруулах талаар сургууль, цэцэрлэгийн удирдлага болон үүсгэн байгуулагчид санал тавих; 35.4.5.захирал, эрхлэгчийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих, дэмжлэг үзүүлэх; 35.4.9.сургууль, цэцэрлэгийн хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлтөд санал өгөх, зайлшгүй нөхцөл байдлын улмаас хүүхдээ 6 наснаас нь сургуульд элсүүлэх боломжгүй талаар малчин эцэг, эхийн гаргасан хүсэлтийг үндэслэж шийдвэрлэх; 35.4.10.сургууль, цэцэрлэгийн батлагдсан төсөв, сангийн зарцуулалтад хяналт тавих, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлттэй танилцах, мэдээлэх; 35.4.11.сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагааны тайланг гаргаж, хамт олны хуралд тайлагнах.

Цэцэрлэгүүд дотоод хяналт хэрэгжүүлэх ажилтан, ажлын хэсэг томилж, хуулийн дагуу⁷ журам боловсруулан, сар улирлын төлөвлөгөө гаргаж, багшийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, хүүхэд хөгжүүлэх, үнэлэх үйл ажиллагаатай холбоотой баримтын бүрдэл, ариун цэвэр, халдвар хамгаалал, эрүүл ахуй зэргийг үнэлж цэцэрлэгийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Тухайлбал: Сайхандулаан сумын цэцэрлэгийн Эрхлэгчийн 2017 оны А/20 тоот тушаалаар байгууллагын дотоод хяналт шалгалтын ажилтан томилж, хяналт шалгалт зохион байгуулах журмыг баталсан байна. Ажилтан дотоод хяналт шалгалт зохион байгуулах удирдамж батлуулан, хэрэгжилтийг тайлагнан ажилладаг байна. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах талаар холбогдох албан тушаалтанд хугацаатай мэдэгдэл хүргүүлж ажилласан байна.

Замын-Үүд сумын 3-р цэцэрлэг 2017 онд дотоод хяналтын журам боловсруулан баталжээ. Дотоод хяналтын жилийн төлөвлөгөө, сар бүр хийх ажлын удирдамж боловсруулан дараах үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна. Цөм хөтөлбөрийн хэрэгжилтэй холбогдуулан Хүүхдийн чөлөөт ажиглалтын тэмдэглэл хөтлөлт, ахицын судалгаа, ажлын тайлан төлөвлөгөө, сургалтын хэрэглэгдэхүүний баяжилт, нэгж хичээлийн төлөвлөлт боловсруулалт, эмх цэгц, хүүхэд бүрийн амжилтыг тооцон ажилласан байдлыг хянасан байна.

Замын-Үүд сумын 5-р цэцэрлэгийн эрхлэгчийн 2019 оны А/02 тоот тушаалаар дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж баталсан байна. 2018-2019 оны хичээлийн жилд дотоод хяналт хийх ажлын төлөвлөгөөг боловсруулж, шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэсэн байна. Харин 2017-2018 оны дотоод хяналттай холбоотой баримт материал байхгүй байна.

БСШУС, СС-ын хамтарсан 2008 оны 56/64 тоот тушаалаар Сургууль цэцэрлэг хөгжүүлэх сангийн үлгэрчилсэн дүрмийг баталсан. Аудитад хамрагдсан цэцэрлэгүүд дүрмийн дагуу цэцэрлэг хөгжүүлэх сан байгуулаагүй байна. Цэцэрлэгүүд эцэг, эх, иргэн ААНБ-аас цуглуулсан хандивыг зөвлөлийн гишүүний дансанд төвлөрүүлсэн бөгөөд хэрхэн төвлөрч, зарцуулсан байдалд хяналт тавьж ажиллаагүй байна. Тухайлбал:

Замын-Үүд сумын 3-р цэцэрлэг: 2018 онд цэцэрлэгийн эцэг эхийн зөвлөл 8 бүлгийн эцэг эхчүүдэд хурал зохион байгуулж хүүхэд тус бүрээс 40.0 мянган төгрөг хураахаар шийдвэрлэсэн байна. Эцэг эхээс нийт 6.8 сая төгрөгийн хандив бүрдсэнээс усан оргилуур, савлуур, ком байшин гэх мэт тоглоом шинээр бэлтгэсэн байна. Хандивын орлогыг зөвлөлийн гишүүний дансанд төвлөрүүлж зарцуулсан байна. Хандивын мөнгөний зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүйгээс үлдэгдэл 1670.0 мянган төгрөгийг дансанд тушаагаагүй жил гаруй хугацаа болсон байв. Аудитын явцад эцэг эхийн зөвлөлийн гишүүнээр 1670.0 мянган төгрөгийг байгууллагын нэмэлт дансанд хийлгэлээ.

Сайншанд сумын 2-р цэцэрлэг: Тус цэцэрлэгийн ойн арга хэмжээтэй холбогдуулан 2017 онд эцэг, эх, иргэн, ААНБ-аас нийт 6.2 сая төгрөгийн хандив цугларсан байна. Тус хандивын мөнгийг 7 сарын хугацаанд зарцуулж дууссан ба мөнгөний зарцуулалтад цэцэрлэгийн эрхлэгч, эцэг эхийн зүгээс хяналт тавиагүй байна. Цэцэрлэгийн зөвлөлийн даргын дансанд хандивыг төвлөрүүлэн

⁷ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.2-д Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн харьяа байгууллага, аж ахуйн нэгж өөрийн аппаратад дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг баталж мөрдүүлнэ.

зарцуулсан бөгөөд хяналтгүйгээс данс эзэмшигч хандивын мөнгөнөөс 1.7 сая төгрөгийг /10.0-290.0 хүртэлх мянган төгрөгийг хувьдаа ашиглан, буцааж тушааж байсан/ гар дээрээ эргэлдүүлж байсан байна.

Эцэг эх, асран хамгаалагчийн цэцэрлэгийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.

Эцэг, эх, асран хамгаалагч нь хуульд⁸ заасны дагуу цэцэрлэгийн сургалтын чанар, хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал, багшийн үйл ажиллагаа, өөрөөс гаргасан хандивын зарцуулалтад санал гаргах, хяналт тавих эрхтэй бөгөөд хичээлийн хэрэглэл, ариун цэврийн хэрэгсэлтэй холбоотой зардлыг хариуцах, сургалтын таатай орчин бүрдүүлэхэд туслах, цэцэрлэгийн эрхлэгчтэй гэрээ байгуулах үүрэгтэй.

Аудитад хамрагдсан цэцэрлэгүүд эцэг эхийн зөвлөл байгуулж, зөвлөлийн ажиллах дүрэм баталж, ажлын төлөвлөгөө боловсруулан ажилласан байна. Эцэг эх, асран хамгаалагч нар хүнсний эрүүл ахуй аюулгүй байдалд хяналт тавих зорилгоор өдөр тутам хоол амталгаа хийх, хоолны нэр төрөл нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулсан уралдаан тэмцээнд тогтмол оролцож үнэлгээ өгөх, эрхлэгчтэй гэрээ байгуулах зэргээр хамтарч ажилладаг байна.

Харин цэцэрлэг хөгжүүлэх үзэл баримтлал, сургалтын хөтөлбөр, дүрэм, журам боловсруулах, үйл ажиллагааны чиглэлийг боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцдоггүй байна.

Цэцэрлэгийн эцэг эхчүүдээс авах санал асуулгад 8 цэцэрлэгийн 70 эцэг эх хамрагдсан бөгөөд *Та хүүхдийнхээ цэцэрлэгийн үйл ажиллагаанд хэрхэн хяналт тавьдаг вэ* гэсэн асуулгад хамрагдсан эцэг эхчүүдийн 40 хувь нь хүүхдийнхээ цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт тавьдаггүй, 60 хувь нь дараах байдлаар хянадаг гэсэн хариултыг ирүүлсэн байна.

- Бүлгийн Facebook чат, суурилуулсан камераар хянадаг
- Хүүхдээсээ тухайн өдрийг хэрхэн өнгөрүүлсэн талаар асуудаг
- Байнга хяналт тавьж чаддаггүй
- Зохион байгуулж байгаа ажил, хурал цуглаанд тогтмол оролцож хянадаг

Б.4.2. Боловсролын газар, мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт шалгалтын дагуу шаардлагатай арга хэмжээг бүрэн авч хэрэгжүүлээгүйгээс шалгалтын үр нөлөө хангалтгүй байна.

⁸СӨБ-ын тухайн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д Эцэг, эх, асран хамгаалагч нь цэцэрлэгийн сургалтын орчин, хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал, сургалтын чанартай холбогдсон санал хүсэлт, гомдол гаргах, хяналт тавих, 14.1.4-д сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ, багшийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар хяналт тавьж, санал гаргах; 14.1.5.хүүхдийг сургах үйл ажиллагаатай холбогдуулан өөрөөс гаргасан зардал, хандивын зарцуулалт, ашиглалтын талаар мэдээлэл авах, хяналт тавих; 14.1.6.цэцэрлэгийг хөгжүүлэх үзэл баримтлал, хөтөлбөр, дүрэм, журам боловсруулах, үйл ажиллагааны чиглэлийг боловсруулах, шийдвэр гаргахад оролцох. 14.2.Эцэг, эх, асран хамгаалагч дараахь үүрэгтэй: 14.2.1.сургуулийн өмнөх боловсролын сургалтад хамрагдаж байгаа хүүхдийн хичээлийн хэрэглэл, ариун цэврийн хэрэгсэлтэй холбоотой зардлыг хариуцах; 14.2.5.өөрийн ажил, мэргэжлийн онцлогийн дагуу цэцэрлэгийн үйл ажиллагаанд оролцож, дэмжиж туслах;14.2.6.хүүхэд сурч хүмүүжих, хөгжих сургалтын таатай орчин бүрдүүлэхэд туслах.14.2.7.хүүхдийн эрүүл, аюулгүй сурч, хөгжих орчин, нөхцөлийг бүрдүүлэх талаар харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлж, цэцэрлэгийн эрхлэгчтэй гэрээ байгуулах;

БСУГ сургуулийн өмнөх боловсрол олгох байгууллага, багшийн үйл ажиллагаанд хяналт ажилласан байна.

Боловсролын тухай хуулийн 28^{1.1.4}-д Аймгийн Боловсролын газар нь боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт-шинжилгээ хийнэ гэж заасан.

БСУГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу цэцэрлэгийн болон, багшийн үйл ажиллагааг боловсруулж гаргасан дараах шалгуур үзүүлэлтийн дагуу жилд 1-2 удаа үнэлж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

БШУС-ын 2013 оны А/293 дугаар тушаалаар батлагдсан Цэцэрлэгийн багшийн үнэлэх, дүгнэх журмын дагуу багшийн үйл ажиллагааг улирал бүр хянаж дүгнэсэн байна.

БСУГ цэцэрлэгийн болон багшийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж байгаа хэдий ч төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан зарим тушаал, шийдвэрийн биелэлтийг хангуулах ажил хангалтгүй байна. Тухайлбал:

БСШУСС-ын 2019 оны А/430 тушаалаар СӨБ-ын байгууллагын ажилтны албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолт баталсан бөгөөд түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсролын газарт даалгасан байна. Тушаалыг хэрэгжилтийг хангуулах талаар чиглэл, арга зүйн зөвлөгөө өгсөн баримт байхгүй байна.

СӨБ-ын тухай хуульд цэцэрлэгийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах чиг үүргийг хуульчилж өгсөн боловч хуулийн дагуу ажиллаж байгаа Зөвлөл байхгүй байгаад хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах талаар арга хэмжээ аваагүй байна.

Зарим цэцэрлэгийн боловсруулсан үзэл баримтлал, дүрэм, сургалтын хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан зэрэг бодлогын баримт бичгүүдыг баримтжуулаагүй, эмх цэгцгүй, архивлаагүй байхад хяналт тавьж, зөвлөмж чиглэл өгөөгүй байна.

БСУГ цэцэрлэгүүдийн төсвийн зарцуулалт, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг мөрдүүлэх талаар зөвлөмж өгч, чиглэлийг цахимаар болон цаасаар тухай бүр хүргүүлэн ажилласан байна.

Мэргэжлийн хяналтын газраас СӨБ-ын боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалтыг жил бүр зохион байгуулсан байна.

МХЕГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө, МХГ-ын даргын баталсан хөтөлбөрийн дагуу төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээг жил бүр үзүүлдэг байна.

2017 онд Сайншанд сумын 2-р цэцэрлэгийн сургалтын өмнөх боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж дараах зөрчлийг илрүүлж, 11-09-027/31 тоот албан шаардлагыг хүргүүлсэн байна. Үүнд:

- Цэцэрлэг хөгжүүлэх хэтийн хөтөлбөр, төлөвлөгөөгүй нь Боловсролын тухай хуулийн 38.3-, СӨБТХ-ийн 11.2.2 заалтуудыг
- Цэцэрлэгийн нэг багшид ногдох ачаалал их байгаа нь багш хүүхэд бүрийг сургах, хөгжүүлэх, сургалтын хэвийн үйл ажиллагаа явуулах, багш, суралцагчдын эрүүл, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байгаа нь СӨБТХ-ийн 9.6-д, 9.9-д заалтыг

- Цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагаа тогтмолжоогүйгээс цэцэрлэгийн удирдлага, зохион байгуулалт, сургалтын чанарын үнэлгээ хийх боломж бүрдээгүй байгаа нь БТХ-ийн 35-р зүйлийн 35.4.3, 35.4.4, 35.4.11 дэх заалтуудыг
- Хүүхдийн нас , сэтгэхүйн онцлогт тохирсон тоглоомоор хангалтгүй нь СӨБТХ-ийн 6.1, СӨБ-ын сургалтын орчин ерөнхий шаардлага MNS 6558:2015 стандартын 6.3.1 заалт
- Эцэг эхчүүд цэцэрлэгийн бодлого боловсруулах, шийдвэр гаргахад оролцох нөхцөл бүрдээгүй нь СӨБТХ-ийн 14.1.6 дах заалтыг
- Цэцэрлэгийн хэмжээнд мөрдөж байгаа эрх зүйн баримт бичигт хууль бус төлбөр хураамж авахгүй байх заалтыг тусгаагүй нь БТХ-ийн 40.7 дахь заалтыг зөрчсөн дутагдлууд гарсан байна.

2018 онд Замын-Үүд сумын 3-р цэцэрлэг, Сайншанд сумын 6-р цэцэрлэг, Замын-үүд сумын 5-р цэцэрлэг, Өргөн сумын цэцэрлэгийн СӨБ эзэмшүүлэх үйл ажиллагаанд хяналт хийж, цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хамран сургах тойргын цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдэд хувилбарт сургалт зохион байгуулах, хүүхдийн ахицыг тогтмол хөтөлж, эцэг эхчүүдэд танилцуулах, дотоод хяналтыг тогтмолжуулж ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн байна.

МХЕГ-ын 2018 оны тандалт судалгаа хийх удирдамжийн дагуу цэцэрлэгүүдийн үйл ажиллагаанд эцэг эхчүүдийн оролцооны байдал, бодлого төлөвлөлтөд санал өгөх, мэдээлэл чөлөөтэй авах, хяналт тавих нөхцөл бүрдсэн эсэхэд тандалт судалгааг цэцэрлэгийн хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдаас санал асуулгын хуудас ашиглан авсан байна.

2019 онд сургалтын орчин MNS6558:2015 стандартын хэрэгжилтийг Замын-Үүд сумын 5-р цэцэрлэг, Сайхандулаан сумын цэцэрлэгийг хамруулж, зөвлөмж өгч ажилласан байна.

Хяналт шалгалтын дагуу шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлээгүйгээс зарим зөрчил арилаагүй байна.

МХГ-ын 2017-2018 оны Зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдсан цэцэрлэгүүд хяналт шалгалтын дагуу шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авч хэрэгжүүлээгүйгээс цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагаа, бодлогын баримт бичиг боловсруулах, хувилбарт сургалт зохион байгуулахтай холбоотой зөрчлүүд давтагдсан хэвээр байна.

МХГ-ын шалгалтад хамрагдсан цэцэрлэгүүд Улсын байцаагчийн зөвлөмж, албан шаардлагын дагуу эрсдлийг бууруулах ажлын төлөвлөгөө гарган тайлагнасан байна.

Сайншанд 11-р цэцэрлэг: 2019 онд багш нарын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдсан дэвтэрт үзлэг шалгалт хийж Нэгдсэн эмнэлэгтэй эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах гэрээ байгуулаагүй, үзлэгт хамрагдсан дэвтрийн санамжтай танилцаж гарын үсэг зураагүй зөрчил илэрсэн. 2019 оны 11-03-031/382 тоот албан шаардлагын дагуу гүйцэтгэх ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хүргүүлсэн байна.

Сайхандулаан сумын цэцэрлэг: 2019 онд СӨБ-ын сургалтын орчин MNS6558:2015 стандартын хэрэгжилтийг хангуулах зөвөлмжийн хэрэгжилтийг хүргүүлсэн байна. Цэцэрлэгийн Зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой зөвлөмж хэрэгжээгүй байна.

Сайншанд 2-р цэцэрлэг: 2017 онд сургалтын өмнөх боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагаатай холбоотой 11-09-027/31 тоот албан шаардлагын хэрэгжилтийн гаргаж хүргүүлээгүй байна.

Замын-Үүд сумын Ухаалаг цэцэрлэг, Замын-Үүд сумын 5-р цэцэрлэг 2019 онд орчны стандарт хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой зөвлөмжийг төсөв, санхүүгийн хүрэлцээгүйгээс хэрэгжүүлж ажиллаагүй.

МХЕГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө, МХГ-ын даргын баталсан хөтөлбөрийн дагуу төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээг жил бүр үзүүлсэн байна.

МХГ-ын 2017-2018 оны Зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдсан цэцэрлэгүүд хяналт шалгалтын дагуу шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авч хэрэгжүүлээгүйгээс цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагаа, бодлогын баримт бичиг боловсруулах, хувилбарт сургалт зохион байгуулахтай холбоотой зөрчлүүд давтагдсан хэвээр байна.

Холбогдох байгууллагын санал



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон, Утас: 7052 2533,
Факс: (976) 7052 2530, И-мэйл: zdtg@dornogovi.gov.mn,
Вэбсайт: dornogovi.gov.mn

2019.11.07. № 2/1899
танай 11.05. -ны № 1-6/585 -т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА Ч.АРИУНАА ТАНАА

Төрийн аудитын газрын 2019 оны аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу "Сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд өгөх саналгүй болно.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ  Т.ЭРДЭНЭЦЭЦЭГ



44 6192328

Аудитын дүгнэлт

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

СӨБ-ын талаарх бодлого оновчтой ч холбогдох яамдын сайд хуулиар заасан дүрэм журмыг бүрэн боловсруулаагүйгээс хэрэгжүүлэх эрх зүйн орчин хангалтгүй, боловсролын үйл ажиллагааны бодлого, хөгжлийн төлөвлөлтийн асуудлаар зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байгуулагдаагүй, Боловсролын газрын ажиллах журмыг боловсруулж ажиллаагүй байна.

СӨБ хариуцах албан тушаалын сул орон тоо нөхөх ажлыг шуурхай зохион байгуулаагүйгээс өнөөг хүртэл томилогдсон албан тушаалтан байхгүй, гэрээт ажилтан түр ажиллаж байна.

Цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагаа тогтмолжоогүйгээс цэцэрлэгийн үйл ажиллагааны тайлан хэлэлцэх, үнэлэх, эрхлэгчийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналт орхигдсон байна.

Цэцэрлэгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага их байгаа ч санхүүгийн хязгаарлагдмал нөөцөөс хамаарч хүн амын нягтаршил, цэцэрлэгийн барилгын чанар байдалтай уялдуулж цөөн тооны цэцэрлэгийн барилга барихаар төлөвлөсөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай бүлэг ажиллуулж, сургуулийн насны хүүхдийг хамруулж байгаа нь холбогдох хуулийн заалтыг зөрчиж байна.

Нэг багшид ногдох хүүхдийн тооны норматив болон цэцэрлэгийн хүчин чадлаас хэтрүүлж хүүхэд авсан, мэргэжлийн багшийн хүрэлцээ дутмаг зэрэг асуудал нь хүүхдүүдэд насан туршийн боловсролын суурь чадварыг бүрэн эзэмшүүлэх үйл ажиллагааны үр дүнг бууруулах эрсдэлтэй байна.

Хувийн цэцэрлэгүүдийн үйл ажиллагааг дэмжих, хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлэх, төрийн цэцэрлэгийн ачааллыг бууруулах бодлого дутагдаж байна.

Нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын хэмжээ бодитой бус байгаагаас төсвийн төлөвлөлт оновчгүй хийгдэж байна. Үүнээс шалтгаалж анхны батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, бусад зардалд болон цэцэрлэгүүдийн хооронд гүйлгэн шилжүүлж байна.

БСШУС-ын 2012 оны А/131 дүгээр тушаалаар баталсан “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалт зохион байгуулах журам”-ын хэрэгжилт хангалтгүй байна.

Аудитаар 301.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж 3.3 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад барагдуулж 298.6 сая төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлага бичлээ.

Аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

БСУГ-ын дарга Ч.Отгонбаяр танаа

- Боловсролын газрын ажиллах журмыг боловсруулах
- Сургуулийн өмнөх боловсрол хариуцах албан тушаалтныг хууль журмын дагуу томилж, ажиллах чиг үүргийг тодорхой болгох
- Цэцэрлэгийн зөвлөл, цэцэрлэг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг тогтмолжуулахад мэргэжил арга зүйн удирдлагаар хангах
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 7^{1.2}-д “Сургуулийн өмнөх боловсролд хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны бүх хүүхдийг хамруулна”, мөн хуулийн 9.9-д “Хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгийн ердийн бүлгийн хүүхдүүдтэй хамт сургаж болох бөгөөд хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүртэл хүүхэд нэг бүлэгт байж болно” гэж заасныг мөрдөж ажиллах.
- Цэцэрлэгүүдийн зардлын гүйцэтгэлд судалгаа хийж төсвийг оновчтой хуваарилах
- БСШУС-ын 2012 оны А/131 дүгээр тушаалаар баталсан “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалт зохион байгуулах журам”-ыг хэрэгжүүлж ажиллах.
- Хувийн цэцэрлэгүүдийн үйл ажиллагааг дэмжиж, төрийн цэцэрлэгийн ачааллыг бууруулах бодлого баримталж ажиллах.

Үндэсний аудитын газраар дамжуулж өгөх санал:

- СӨБ-ын талаарх бодлогод нийцүүлэн хуулиар заасан дүрэм журмыг бүрэн боловсруулж, хэрэгжүүлэхийг холбогдох яамдын сайдад хүргүүлэх
- Хувьсах зардлын нрмативаар санхүүжүүлж буй тогтолцоонд өөрчлөлт оруулж бодит байдалтай нийцүүлэх саналыг БСШУСС-д хүргүүлэх

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА



АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД :

Ахлах аудитор

Ц.Лүндэгмаа

Аудитор

П.Энхбаяр

ХЯНАСАН:

Аудитын менежерийн үүргийг

орлон гүйцэтгэгч

Э.Энхцэцэг



АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД

ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.